

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛООР ЗАСГИЙН ГАЗАРТ ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ШИЙДВЭРИЙН
2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАНИЛЦУУЛГА**

/Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд/

2020.07.22

Улаанбаатар хот

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас “Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоол, шийдвэрийн 2019 оны жилийн эцсийн хэрэгжилтийн тайлан”-г 2020 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн ХЭГ/1503 тоот албан бичгээр Улсын Их Хурлын Тамгын газарт ирүүлсэн.

“Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн шийдвэрийн 2019 оны жилийн эцсийн хэрэгжилтийн танилцуулга”-ыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тайланд шинжилгээ хийж, Байнгын хорооны эрхлэх асуудал тус бүрээр ялган гаргасан болно. Шинжилгээний дүнд үндэслэн бүрэн хэрэгжсэн хууль тогтоомжийн хэсэг, заалтыг хяналтаас хасах саналыг хавсаргав.

“Монгол Улсын Засгийн газарт хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор үүрэг, чиглэл өгсөн шийдвэрийн 2019 оны жилийн эцсийн хэрэгжилтийн танилцуулга”-ыг Улсын Их Хурлын www.parliament.mn цахим сүлжээнд байршуулсан болно.

**ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ХУУЛИАР ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ЗАСГИЙН
ГАЗРЫН ГИШҮҮДЭД ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ХЭСЭГ, ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН
ТАЛААР**

2.1. Монгол Улсын хуулийн хэрэгжилт

Монгол Улсын хуулиар Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд хууль хэрэгжүүлэхтэй холбогдуулан дүрэм, журам, жагсаалтыг батлан гаргах үүрэг өгсөн 105 хуулийн 527 хэсэг, заалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний хэлтэс хяналтанд авч, мэдээллийн санд бүртгэсэн болно.

2019 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 99 хуулийн 427 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс хяналтад байгаа 99 хуулийн 426 заалт буюу 80.8 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 12 /давхардсан тоогоор/ хуулийн 101 заалт буюу 19.2 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Харин өмнөх онуудад хяналтаас хасагдсан 1 хуулийн 1 заалтын хэрэгжилтийн мэдээг дахин ирүүлсэн байна.

		Хууль /давхардсан тоогоор/	Хэсэг, заалт
1	2019 оны жилийн эцсийн байдлаар хяналтад авсан	105	527
2	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн Үүнээс:	99	427
	- Хяналтад байгаа	99	426
	- Хяналтаас хасагдсан заалтыг дахин ирүүлсэн	1	1
3	Засгийн газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	12	101

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 99 хуулийн 427 хэсэг, заалтаас давхардсан тоогоор 67 хуулийн 250 хэсэг, заалт буюу 58.5 хувь нь бүрэн хэрэгжсэн, 28 хуулийн 54 хэсэг, заалт буюу 12.6 хувь нь хэрэгжих шатанд, 18 хуулийн 36 хэсэг, заалт буюу 8.4 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 23 хуулийн 29 хэсэг, заалт буюу 6.8 хувь нь хэрэгжээгүй, 25 хуулийн 58 хэсэг, заалт буюу 13.6 хувь нь үнэлэх боломжгүй мэдээ ирүүлсэн байна.

2.2. Монгол Улсын хуулиар Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд тусгайлан үүрэг өгсөн хэсэг, заалтын хэрэгжилт

Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг өгсөн Монгол Улсын 21 хуулийн 95 хэсэг, заалтыг Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны 17 хуулийн 84 хэсэг, заалт буюу 88.4 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлснээс давхардсан тоогоор 11 хуулийн 39 хэсэг, заалт буюу 46.4 хувь нь бүрэн хэрэгжсэн, 8 хуулийн 16 хэсэг, заалт буюу 19.0 хувь нь хэрэгжих шатанд, 2 хуулийн 3 хэсэг, заалт буюу 3.6 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 2 хуулийн 3 хэсэг, заалт буюу 3.6 хувь нь хэрэгжээгүй, 11 хуулийн 23 хэсэг, заалт буюу 27.4 хувь нь үнэлэх боломжгүй байна.

	Хууль /давхардсан тоогоор/		Хэсэг, заалт
	Тоо	Тоо	Хувь
Хяналтанд авсан	21	95	100.0
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	17	84	88.4
Үүнээс:			
- бүрэн хэрэгжсэн	11	39	46.4
- хэрэгжих шатанд	8	16	19.0
- хэрэгжилт хангалтгүй	2	3	3.6
- хэрэгжээгүй	2	3	3.6
- үнэлэх боломжгүй	11	23	27.4

2.3. Мэдээнд гарсан зөрчил

Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд байгаа Монгол Улсын 6 хуулийн 11 хэсэг, заалт буюу 11.6 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Үүнд:

№	Хуулийн нэр	Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй хуулийн хэсэг, заалт
1	Банкны тухай /шинэчилсэн найруулга 2010.01.28/	54.3 дахь заалт;
2	Жолоочийн даатгалын тухай /2011.10.06/	15.5; 17.4; 19.8; 20.6; 26.4 дэх заалт;
3	Инновацийн тухай /2012.05.22/	17.1.12 дахь заалт;
4	Чөлөөт бүсийн тухай /шинэчилсэн найруулга 2015.02.12/	24.1 дэх заалт;
5	Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2015.06.19/	5.3.5; 5.3.7 дахь заалт;
6	Хөгжлийн банкны тухай /шинэчилсэн найруулга 2017.02.10/	15.1 дэх заалт;

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

3.1. Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2019 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлаас Засгийн газарт үүрэг өгсөн нийт 70 тогтоолын 238 заалтыг хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар 2019 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 55 тогтоолын 171 заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс хяналтад байгаа 38 тогтоолын 118 заалт буюу 49.6 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, давхардсан тоогоор 40 тогтоолын 120 заалт буюу 50.4 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Мөн өмнөх онуудад хяналтаас хасагдсан 24 тогтоолын 53 заалтын хэрэгжилтийн мэдээг дахин ирүүлсэн байна.

		Тогтоол /давхардсан тоогоор/	Заалт
1	2019 оны жилийн эцсийн байдлаар хяналтанд авсан	70	238
2	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн Үүнээс:	55	171
	- Хяналтанд байгаа	38	118
	- Хяналтаас хасагдсан заалтыг дахин ирүүлсэн	24	53
3	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	40	120

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн Улсын Их Хурлын 38 тогтоолын 118 заалтаас давхардсан тоогоор 30 тогтоолын 74 заалт буюу 62.7 хувь нь бүрэн хэрэгжсэн, 11 тогтоолын 31 заалт буюу 26.3 хувь нь хэрэгжих шатанд, 7 тогтоолын 9 заалт буюу 7.6 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 1 тогтоолын 1 заалт буюу 0.9 хувь нь хэрэгжээгүй, 3 тогтоолын 3 заалт буюу 2.5 хувь нь хэрэгжих хугацаа болоогүй байна.

3.2. Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн 21 тогтоолын 73 заалтыг Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналт тавин ажиллаж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний 9 тогтоолын 28 заалт буюу 38.4 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлснээс 7 тогтоолын 16 заалт буюу 57.1 хувь нь бүрэн хэрэгжсэн, 3 тогтоолын 9 заалт буюу 32.1 хувь нь хэрэгжих шатанд, 1 тогтоолын 1 заалт буюу 3.6 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 2 тогтоолын 2 заалт буюу 7.2 хувь үнэлэх боломжгүй байна.

Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	УИХ-ын тогтоол /давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
<i>Хяналтанд авсан</i>	21	73	100.0
<i>Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн</i>	9	28	38.4
Үүнээс:			
- <i>Бүрэн хэрэгжсэн</i>	7	16	57.1
- <i>Хэрэгжих шатанд</i>	3	9	32.1
- <i>Хэрэгжилт хангалтгүй</i>	1	1	3.6
- <i>Хэрэгжээгүй</i>	-	-	-
- <i>Үнэлэх боломжгүй</i>	2	2	7.2

3.3. Мэдээнд гарсан зөрчил

Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд байгаа дараах Улсын Их Хурлын 15 тогтоолын 45 заалт буюу 61.6 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Үүнд:

№	Улсын Их Хурлын тогтоолын нэр	Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй тогтоолын заалт
1	Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай /2012.01.05 №01/	1.2; 1.3 дахь заалт;
2	Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай /2012.10.25 №01/	2; 3 дахь заалт;
3	Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1 дэх заалт;

	хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай /2014.06.05 №41/	
4	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай /2014.11.13 №69/	2.1; 2.2; 2.5; 3.1; 3.2; 5.1 дахь заалт;
5	Өрийн удирдлагын тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай /2015.02.18 №42/	2 дахь заалт;
6	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай /2015.11.13 №93/	3.1; 3.2; 3.4 дэх заалт;
7	Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай /2016.09.07 №40/	2; 3 дахь заалт;
8	Монгол Улсын Хөгжлийн банкны талаар авах зарим арга хэмжээний тухай /2016.12.28 №81/	1.1 дэх заалт;
9	Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай /2018.06.29 №73/	1.5; 1.6 дахь заалт;
10	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай /2018.11.15 №84/	7 дахь заалт.
11	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай /2019.05.30 №54/	2; 3 дахь заалт;
12	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль /Шинэчилсэн найруулга/ баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай /2019.06.06 №61/	1; 2; 3; 5; 6 дахь заалт;
13	Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай /2019.09.13 №74/	1; 2 дахь заалт;
14	Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай /2019.11.21 №92/	1; 2; 3; 4; 5; 6; 7 дахь заалт;
15	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2020 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай /2019.12.05 №98/	2.1; 2.2; 2.3; 2.4; 2.5; 2.6; 2.7; 2.8 дахь заалт.

ДӨРӨВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООДЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

4.1. Байнгын хороодын тогтоолын хэрэгжилт

Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2019 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын Байнгын хороодоос Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн нийт 99 тогтоолын 674 заалтыг мэдээллийн санд бүртгэж, хяналтанд авсан.

2019 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 82 тогтоолын 420 заалт буюу 62.3 хувийн хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн нь бүгд хяналтанд байх заалтууд байна. Давхардсан тоогоор 48 тогтоолын 254 заалт буюу 37.7 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

		Тогтоол /давхардсан тоогоор/	Заалт
1	2019 оны жилийн эцсийн байдлаар хяналтад авсан	99	674
2	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн Үүнээс:	82	420
	- Хяналтанд байгаа	82	420
	- Хяналтаас хасагдсан заалтыг дахин ирүүлсэн	-	-
3	ЗГХЭГ-аас 2019 оны жилийн эцсийн байдлаар	48	254

хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй		
-------------------------------	--	--

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 82 тогтоолын 420 заалтаас давхардсан тоогоор 65 тогтоолын 252 заалт буюу 60.0 хувь нь бүрэн хэрэгжсэн, 47 тогтоолын 100 заалт буюу 23.8 хувь нь хэрэгжих шатанд, 20 тогтоолын 26 заалт буюу 6.2 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 11 тогтоолын 28 заалт буюу 6.7 хувь нь хэрэгжээгүй, 12 тогтоолын 14 заалт буюу 3.3 хувь нь үнэлэх боломжгүй гэсэн мэдээ ирүүлсэн байна.

4.2. Эдийн засгийн байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн Эдийн засгийн байнгын хорооны 18 тогтоолын 151 заалтыг Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналт тавин ажиллаж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний 15 тогтоолын 81 заалт буюу 53.6 хувийн хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс 14 тогтоолын 63 заалт буюу 77.8 хувь нь бүрэн хэрэгжсэн, 7 тогтоолын 8 заалт буюу 9.9 хувь нь хэрэгжих шатанд, 3 тогтоолын 3 заалт буюу 3.7 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 1 тогтоолын 3 заалт буюу 3.7 хувь нь хэрэгжээгүй, 4 тогтоолын 4 заалт буюу 4.9 хувь нь үнэлэх боломжгүй байна.

Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	ЭЗБХ-ны тогтоол /давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
<i>Хяналтанд авсан</i>	18	151	100.0
<i>Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн</i>	15	81	53.6
Үүнээс:			
- <i>Бүрэн хэрэгжсэн</i>	14	63	77.8
- <i>Хэрэгжих шатанд</i>	7	8	9.9
- <i>Хэрэгжилт хангалтгүй</i>	3	3	3.7
- <i>Хэрэгжээгүй</i>	1	3	3.7
- <i>Үнэлэх боломжгүй</i>	4	4	4.9

4.3. Мэдээнд гарсан зөрчил

Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд байгаа 18 тогтоолын 151 заалтаас 12 тогтоолын 70 заалт буюу 46.4 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Үүнд:

№	Тогтоолын нэр	Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй тогтоолын заалт
1	Валютын ханш, газрын тосны бүтээгдэхүүний үнийн тогтвортой байдлыг хангах талаар цаашид авах арга хэмжээний тухай /2012.02.08 №10/	2.5; 3 дахь заалт;
2	Шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний талаар /2015.04.08 №10/	2 дахь заалт;

3	Чиглэл өгөх тухай /2016.11.29 №07/	1.3/; 1.4/; 1.5/; 1.6/; 2 дахь заалт;
4	Чиглэл өгөх тухай /2017.06.07 №15/	1.7/; 2 дахь заалт;
5	Чиглэл өгөх тухай /2017.06.07 №16/	1.1/; 1.2/; 1.3/; 1.4/; 1.5/; 1.6/; 1.7/; 2.1/; 2.2/; 2.3/; 2.4/; 2.5/; 2.6/; 3 дахь заалт;
6	Банкны зээлийн хүүг бууруулах зах зээлийн орчныг бүрдүүлэх талаар чиглэл өгөх тухай /2018.04.18 №07/	2.1/; 2.2/; 2.3/; 2.4/; 4; 5 дахь заалт;
7	Чиглэл өгөх тухай /2018.04.25 №08/	1.1/; 1.2/; 1.3/; 1.4/; 2.1/; 2.2/; 2.3/; 2.4/; 2.5/; 3 дахь заалт;
8	Чиглэл өгөх тухай /2018.05.02 №10/	1.1/; 1.2/; 1.3/; 1.4/; 1.5/; 1.6/; 1.7/; 1.8/; 1.9/; 1.10/; 1.11/; 1.12/; 1.13/; 2 дахь заалт;
9	Чиглэл өгөх тухай /2018.06.05 №17/	1.1/; 1.3/; 1.4/ дэх заалт;
10	Чиглэл өгөх тухай /2018.10.30 №32/	1.1/; 1.3/; 1.4/; 3 дахь заалт;
11	Ипотекийн зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар чиглэл өгөх тухай /2018.11.13 №35/	4 дэх заалт;
12	Экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газар, Монголбанканд чиглэл өгөх тухай /2019.04.09 №04/	1.4/; 1.5/; 1.6/; 1.7/; 2.2/; 2.3/; 2.4/; 3 дахь заалт.

ТАВ. БҮРЭН БИЕЛСЭН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ХЯНАЛТААС ХАСАХ ТУХАЙ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд бүрэн хэрэгжсэн Монгол Улсын 11 хуулийн 39 хэсэг, заалт, Улсын Их Хурлын 7 тогтоолын 16 заалт, Эдийн засгийн байнгын хорооны 14 тогтоолын 63 заалтыг хяналтаас хасах санал ирүүлснийг хавсралтаар хүргүүлэв.

ЗУРГАА. САНАЛ

1/ Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас тус Байнгын хорооны эрхлэх асуудалд хамаарах хяналтад байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээг хангалтгүй ирүүлж байна. Тухайлбал тус Байнгын хорооны эрхлэх асуудалд хамаарах хяналтад байгаа Улсын Их Хурлын 15 тогтоолын 45 заалт буюу 61.6 хувь, Эдийн засгийн байнгын хорооны 12 тогтоолын 70 заалт буюу 46.4 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй болно.

2/ Цаашид хэрэгжилтийг сайжруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч, хариуцсан яамд, агентлагуудад үүрэг, чиглэл өгч ажиллах нь зүйтэй.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД
БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ /ХЭСЭГ, ЗААЛТ/-ИЙН ЖАГСААЛТ
/2019 оны жилийн эцсийн байдлаар/**

№	Хуулийн нэр, огноо	Заалтын агуулга	Хэрэгжилт
1.	Жолоочийн даатгалын тухай 2011.10.06	8.3. Даатгалын баталгааны загвар, хэрэглэх журмыг Санхүүгийн зохицуулах хорооны дарга хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.	“Жолоочийн даатгалын баталгааны загвар, хэрэглэх журам”-ыг Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 29/А13 дугаар хамтарсан тушаалаар баталсан.
2.	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай 2015.06.26	8.1.7. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөлд оролцогчдын хооронд байгуулах гурван талт гэрээний үлгэрчилсэн загварыг батлах.	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг дагалдах нийт 7 журмыг боловсруулж батлуулсан. Үүнд: “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх талбайг сонгох үлгэрчилсэн журам”-ыг БХБ-ын сайдын 2016 оны 84 дүгээр, “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөлд оролцогчдын хооронд байгуулах гурван талт гэрээний үлгэрчилсэн загвар”-ыг БХБ-ын сайдын 2016 оны 125 дугаар, “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам”-ыг БХБ-ын сайдын 2016 оны 126 дугаар, “Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журам”-ыг БХБ-ын 2018 оны 46 дугаар, “Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах үйл ажиллагааны журам”-ыг БХБ-ын сайдын 2018 оны өдрийн 202 дугаар тушаалаар тус тус батлан, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 3644, 3656, 3658, 3880, 4169 дугаарт бүртгүүлсэн. “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны нөхөх олговор олгох журам”-ыг Засгийн газрын 2018 оны 222 дугаар тогтоолоор, “Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах зорилгоор өмчлөгч, эзэмшигч газраар хувь нийлүүлэх журам”-ыг Засгийн газрын 2018 оны 341 дүгээр тогтоолоор тус тус батлуулан эдгээр дүрэм, журмуудын хэрэгжилтийг ханган ажиллах чиглэлийг харьяа агентлаг, аймаг, нийслэлийн холбогдох байгууллагуудад хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
3.	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай 2015.11.26	11.4. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн гүйцэтгэлд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. 13.2. Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүсчилсэн хөгжлийн бодлогыг боловсруулах ажлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран	Засгийн газрын 2019 оны 290 дүгээр тогтоолоор тодотгон баталсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-д туссан төсөл хөтөлбөрийн 2019 оны гүйцэтгэлийг нэгтгэж, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан, танилцуулгыг 2020.05.20-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Монгол Улсын Ерөнхий сайдын 2017.11.16-ны өдрийн 165 тоот захирамжаар “Эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах бодлого боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөмж өгөх үүрэг бүхий Ажлын хэсэг”-ийг байгуулж, бүрэлдэхүүнд салбар яамдын төлөөлөл, эрдэмтэн судлаачдыг багтаасан. Үндэсний хөгжлийн газрын даргын 2018.04.10-ны өдрийн А-48, А-49 тоот

		<p>зохион байгуулна.</p>	<p>“Үнэлгээний хороо байгуулах тухай” тушаал батлагдаж, 158 сая төгрөгийн санхүүжилтээр 17 салбарын бодлогын судалгааны ажлыг зөвлөх сонгон шалгаруулж, гүйцэтгэсэн. ҮХГ-ын даргын 2019.03.25-ны өдрийн А48 тоот тушаалаар “Бүсчилсэн хөгжлийн бодлогын хувилбар” төсөл боловсруулах зөвлөх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороо байгуулагдсан. Тус үнэлгээний хороо “Төр болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах” хууль болон холбогдох хууль журмын дагуу ажиллаж “Бүсчилсэн хөгжлийн бодлогын хувилбар” төсөл боловсруулах зөвлөх хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, Захиалагч 2019.07.03-ны өдөр “Макро эдийн засаг ба эрүүл мэнд” ТББ-тай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан ажилласан. “Бүсчилсэн хөгжлийн бодлогын хувилбар” төсөл боловсруулах зөвлөх баг 3 шатны тайланг боловсруулан эхний тайлангийн хэлэлцүүлгийг 2019.10.17-ны өдөр Үндэсний хөгжлийн газрын хурлын танхимд Үндэсний хөгжлийн газрын Аргазүйн зөвлөл, Шинжлэх ухааны зөвлөл, салбарын яамдын төлөөлөл, их дээд сургууль, эрдэмтэн судлаачид, хувийн хэвшлийн төлөөллийн хүрээнд зохион байгуулсан. Дунд хугацааны тайлангийн хэлэлцүүлэг 10 дугаар сарын 29-ний өдөр ЗГХЭГ-ын дарга, зөвлөхүүд, бүх яамдын төлөөлөл, их дээд сургуулийн эрдэмтэн судлаачид, “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого-2050”, “түүнийг хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөний төсөл” боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүдийн хүрээнд Удирдлагын академийн хурлын танхимд зохион байгуулсан. “Бүсчилсэн хөгжлийн бодлогын хувилбар” төслийн эцсийн шатны хэлэлцүүлгийг 2019.12.26-ны өдөр МУИС-ийн номын санд зохион байгуулсан. “Бүсчилсэн хөгжлийн бодлого”-ын төслийг боловсруулж, “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого-2050”, “түүнийг хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөний төсөл” боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт хүргүүлсэн ба ажлын хэсгээс Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого-2050” бодлогын баримт бичгийн нэг хэсэг болгох, бодлогын баримт бичгийн холбогдох хэсгүүдийг хасч, үзэл баримтлалын шаардлагад нийцлүүлэн “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” болгохоор шийдвэрлэсэн.</p>
		<p>13.5. Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн саналд үндэслэн бүсчилсэн хөгжлийн бодлогын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулна.</p>	<p>“Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэлэлцүүлэг”-ийг 21 аймагт амжилттай зохион байгуулсан. /Өмнөговь аймагт 2019.02.26-нд, Дундговь аймагт 2019.02.28-нд, Говьсүмбэр аймагт 2019.03.15-нд, Хэнтий аймагт 2019.03.26-нд, Сүхбаатар аймагт 2019.03.27-нд, Орхон аймагт 2019.04.09-нд, Хөвсгөл аймагт 2019.04.11-нд, Дорноговь аймагт 2019.04.19-нд, Сэлэнгэ аймагт 2019.04.25-нд, Дархан-Уул аймагт 2019.04.26-нд, Өвөрхангай аймагт 2019.05.08-нд, Архангай аймагт 2019.05.10-нд, Баянхонгор аймагт 2019.06.10-нд, Говь-Алтай аймагт 2019.06.11-нд, Ховд аймагт 2019.06.13-нд, Баян-Өлгий аймагт 2019.06.14-нд, Увс аймагт 2019.06.17-нд, Завхан аймагт 2019.06.19-нд, Булган аймагт 2019.06.21-нд, Төв аймагт 2019.06.24-нд, Дорнод аймагт 2019.08.01-нд тус тус зохион байгуулсан./</p> <p>Тус хэлэлцүүлэгт аймгийн болон бүх сумдын Засаг дарга, ИТХ-ын тэргүүлэгчид, холбогдох газар хэлтсийн албан тушаалтнууд, эрдэмтэн судлаачид, хувийн хэвшлийн төлөөлөл, иргэд олон нийтийн төлөөлөл оролцож “Бүсчилсэн хөгжлийн бодлого”-ын төсөлд тусгах санал, зөвлөмж өгсөн. “Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэлэлцүүлэг”-ийг 21 аймагт зохион байгуулах ажилд Германы Олон улсын хамтын</p>

			ажиллагааны нийгэмлэгийн ЭТИС хөтөлбөр (GIZ), Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА) дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан. Тус Бүсчилсэн хөгжлийн бодлогыг Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал болгон найруулж, "Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого-2050" бодлогын баримт бичгийн нэг хэсэг болгохоор шийдвэрлэсэн. Бүсчилсэн хөгжлийн бодлогыг 2020.05.07-ны өдөр батлагдсан Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу дахин боловсруулж, УИХ-д өргөн барихаар болсон.
4.	Барилгын тухай /шинэчилсэн найруулга/ 2016.02.05	6.3. Барилгын үйл ажиллагаанд олон улсын байгууллага, гадаадын барилга байгууламжийн норм, дүрэм, стандартыг бүртгэх, хэрэглэх журмыг Засгийн газар батална.	"Барилгын үйл ажиллагаанд олон улсын байгууллага, гадаадын барилга байгууламжийн норм, дүрэм, стандартыг бүртгэх, хэрэглэх журам"-ын төсөлд ЗГХЭГ болон БХБ-ын сайдын зөвлөх Б.Баасангийн өгсөн санал зөвлөмжид үндэслэн дахин боловсруулж ЗГХЭГ-т 2019.03.05-ны өдрийн 01/774 албан тоотой хүргүүлсэн. Журмыг Засгийн газрын 03 дугаар сарын 21-ний 107 дугаар тогтоолоор батлуулсан. Олон улсын байгууллага, гадаадын барилга байгууламжийн норм, дүрэм, стандартыг бүртгүүлэхээр байгууллагуудаас санал ирүүлээгүй байна. Тухай бүр бүртгэх, хэрэглэх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.
5.	Авто замын тухай /Шинэчилсэн найруулга/ 2017.05.11	9.1.7. олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжийн ашиглалтын хэвийн нөхцөл, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор норм, нормативаар тогтоосон авто замын арчлалт, урсгал засварын ажилд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусган батлуулах, хэрэгжилтийг хангуулах; 9.1.8. тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журам батлах. 10.1.7. тусгай зориулалтын авто зам барих, засварлах, ашиглахтай холбоотой журмыг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах; 24.7. Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журмыг Засгийн газар батална. 26.2. Авто замын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Монгол Улсын 2020 оны төсвийн Зам, тээврийн хөгжлийн сайдын багцад 52 тэрбум төгрөгийн төсвийг олон улс, улсын чанартай авто замын арчлалт, урсгал засварын зардалд тусгасан. "Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журам"-ыг 2018 оны 12 дугаар сард Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж баталсан. "Тусгай зориулалтын авто зам барих, засварлах, ашиглах журам"-ыг 2018 оны 12 дугаар сард Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан. Журмыг мөрдөн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хяналтаас хасах саналтай байна. "Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам"-ын төсөлд яамдаас санал авч, Азийн хөгжлийн банкны "Техник туслалцааны төсөл"-ийн багтай хамтран ажиллаж, журмын төслийг Засгийн газрын 2019.07.03-ны хуралдаанд хэлэлцүүлэн Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолоор батлуулсан. "Авто замын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам"-ыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 11-ний өдөр 282 дугаар тушаалаар батлуулсан.

		27.4. Олон улс, улсын болон тусгай зориулалтын авто замын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх, мэдээлэх журмыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, нийслэл, орон нутгийн чанартай авто замын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх, мэдээлэх журмыг аймаг, нийслэлийн Засаг дарга баталж, мөрдүүлнэ.	"Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх, мэдээлэх журам"-ыг 2019 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн сайдын 106 дугаар тушаалаар баталсан.
		30.1. Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах замын чиглэл, замын урт, төлбөрийн хэмжээг Засгийн газар, нийслэл, орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах замын чиглэл, замын урт, төлбөрийн хэмжээг тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тус тус тогтооно.	Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс авах төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2016.02.15-ны №103 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан. Хуулийн заалтын дагуу олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах үйл ажиллагааг "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ хэрэгжүүлэн ажиллаж байна.
		30.2. Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах журмыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Авто замын тухай хуулийн 30.2 дугаар зүйлийн дагуу Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 274 дүгээр тушаалаар "Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах журам"-ыг шинэчлэн баталж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 4281 дугаарт 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр бүртгүүлэн мөрдөж байна.
		31.2. Авто зам, замын байгууламжийг хаах, замын чиглэл өөрчлөх журмыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	"Авто зам, замын байгууламжийг хаах, замын чиглэл өөрчлөх журам"-ыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 161 дүгээр тушаалаар баталсан.
6.	Усан замын тээврийн тухай /шинэчилсэн найруулга/ 2017.05.25	5.1.5. усан замын тээврийн хэрэгслийн ангилал, зориулалтыг харгалзан техникийн хяналтын үзлэгийн төлбөрийн жишгийг ялгавартай тогтоох.	Усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн төлбөрийн жишиг тогтоох тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, Засгийн газрын 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанд хэлэлцүүлж, 248 дугаар тогтоолоор батлуулсан.
		6.1.5. тээвэрлэлтийн үйл ажиллагаа, усан замын тээврийн хэрэгсэл, усан замын төв буудал, зогсоол, аврах хэрэгсэл, тоног төхөөрөмжийн техник ашиглалтын талаар мөрдөх нийтлэг дүрэм, журам, норм, нормативыг батлах, биелэлтийг хангуулах;	Тус заалтын дагуу 3 дүрэм, 3 журмыг шинээр боловсруулж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэн улс даяар дагаж мөрдүүлэв. Үүнд: 1. Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын дүрэм; /шинээр/ 2. Усан замын объект болон усан замын тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дүрэм; /шинээр/ 3. Усан замын тээврийн хэрэгслээр зорчигч, ачаа тээвэрлэх дүрэм. /шинээр/ 4. Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам; /өөрчлөлт/

			<p>5. Усан замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектод гэрчилгээ олгох журам; /шинээр/</p> <p>6. Усан замын тээврийн боловсон хүчин, тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх журам; /шинээр/</p> <p>7. Усан замын тээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам /Өөрчлөх, шинэчлэх шаардлагагүй/ ЗТАЖЯ 2006.04.05 №45 Улсын бүртгэл 2006.09.27 №2637</p>
		6.1.9. усан замын тээврийн боловсон хүчин, тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх журам, сургалтын хөтөлбөрийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;	Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх журам, сургалтын жишиг хөтөлбөрийг шинээр боловсруулан Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу журмын болон сургалтын жишиг хөтөлбөрийн төсөлд нөлөөллийн шинжилгээ хийж, эрх ашиг нь хөндөгдөж болох этгээдүүд болох завьчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, Зам, тээврийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нарын хамтарсан 2019 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 269/A/271 дугаар тушаалаар батлуулав. Журмыг ХЗДХЯ-нд хүргүүлж захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 4466 дугаарт бүртгүүлсэн.
		6.1.12. усан замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектод гэрчилгээ олгох журам, гэрчилгээний загварыг батлах;	Тус журмыг шинээр боловсруулан Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу журмын төсөлд нөлөөллийн шинжилгээ хийж, эрх ашиг нь хөндөгдөж болох этгээдүүд болох завьчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, Сайдын 2019.03.15-ны өдрийн 78 дугаар тушаалаар батлуулсан. Журмыг ХЗДХЯ-нд хүргүүлж Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 4283 дугаарт бүртгүүлэв.
		6.1.13. усан замын объект болон усан замын тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дүрмийг батлах;	Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 277 дугаар тушаалаар "Усан замын объект болон усан замын тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дүрэм" батлагдсан.
7.	Концессын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2017.04.14	9.5. Концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь концессын зүйлийн жагсаалтын талаархи саналаа энэ хуулийн 10.3-т заасны дагуу болон зардал, ашгийн тооцооны хамт боловсруулж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр Засгийн газарт хүргүүлнэ.	<p>УИХ-ын 2009 оны 64 дүгээр тогтоолоор Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого, Концессын тухай хуулийг 2010 онд тус тус баталсан. Концессын тухай хуулийн дагуу Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтыг баталсан. Уг жагсаалтад нийт 247 төсөл байгаагаас эрчим хүчний 21, авто замын 34, боловсролын салбарын барилга байгууламжийн 123, дэд бүтцийн 32, эрүүл мэндийн 13, бусад 24 төсөл багтсан. Дээрх жагсаалтаас нийт 54 төслийн концессын гэрээг байгуулсан /Цуцлагдсан гэрээнүүд хамрагдаагүй/-аас 23 төсөл бүрэн хэрэгжиж дууссан ба одоогоор хэрэгжиж буй 31 төсөл байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • "Барих-Шилжүүлэх" төрлийн 14 гэрээ • "Барих-Шилжүүлэх"-ээс бусад төрлийн 17 гэрээ байна. <p>Концессын зүйлийн жагсаалтад нэмэлт оруулах, жагсаалтаас хасах, жагсаалтад дурдагдсан томьёоллыг өөрчлөх ажлуудыг хийж гүйцэтгэхдээ Концессын зүйлийн талаарх саналыг зардал, ашгийн тооцооны хамт боловсруулж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр Засгийн газарт хүргүүлдэг.</p>
		10.1. Төсвийн тухай хуулийн 33.2.9-т	2013 оны Концессын зүйлийн жагсаалтад 2017 онд Засгийн газрын

		зааснаас бусад төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтыг Засгийн газар батална. /33.2.9.Концессын тухай хуулийн 4.1.2-т заасан төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, тэдгээрт тавигдах тусгай шаардлага, нөхцөл./	24,59,84,166,277,296 тоот тогтоолуудаар 7 концессын зүйлийг нэмж, 2 концессын зүйлд өөрчлөлт оруулж, 1 концессын зүйлийг хүчингүй болгосон байна. Түүнчлэн Засгийн газрын тогтоолоор 2018, 2019, 2020 онуудад зохих нэмэлт, өөрчлөлтүүдийг тус тус оруулсан болно.
8.	Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай /Шинэчилсэн найруулга/ 2017.12.21	6.1. Техникийн зохицуулалтыг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал, энэ хуулийн 6.4-т заасан дүгнэлтийг үндэслэн Засгийн газар батална. /6.4.Техникийн зохицуулалтын төсөл нь энэ хуулийн 5.1-д заасан зорилго, 6.2-т заасан шаардлагыг хангасан эсэх талаар стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дүгнэлт гаргана./	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2017 оны 87 дугаар тогтоол болон Үндэсний стандартын баримт бичгийн улсын үзлэгийн дүнг үндэслэн Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор салбар бүрийн нэн шаардлагатай 18 техникийн зохицуулалтыг баримт бичгийн жагсаалтыг Засгийн газрын 2019 оны 235 тогтоолоор батлуулсан.
		6.2. Техникийн зохицуулалт боловсруулах зааврыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.	Захиргааны ерөнхий хуулийн 60-62-р зүйл, ЗГ-ын 89 тогтоол СХЗГ даргын 2018 оны 09 сарын 26-ны А/313 тушаалаар Техникийн зохицуулалт боловсруулах арга зүйн заавар боловсруулж баталсан.
		6.3. Шаардлагатай тохиолдолд техникийн зохицуулалтыг хэрэгжүүлэх журмыг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	СХЗГ даргын 2018 оны 09 сарын 26-ны А/313 тушаалаар “Техникийн зохицуулалтад шүүлт хийх журам” баталсан.
		6.5. Монгол Улсаас гадаад худалдаанд хэрэглэх техникийн зохицуулалтын төслийг батлагдахаас гурваас доошгүй сарын өмнө стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орнуудад мэдээлнэ.	Дэлхийн худалдааны байгууллагад дараах баримт бичгийг 2019, 2020 онуудад тус тус мэдэгдсэн Үүнд: 1. ЗГ-ын 2018 оны 291 дүгээр тогтоолын 1, 2 дугаар хавсралт “Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт” 2. Тохирлын баталгаатай бүтээгдэхүүн, үйлчилгээг Монгол Улсын зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэх журам 3. СХЗГ-ын даргын 2018 оны 291 дүгээр тушаал баталсан “Аюулгүйн тэмдгийн хэлбэр, хэрэглэх журам”
		9.1. Үндэсний стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.	2020 оны 01-р улирлын байдлаар нийт 24 стандарт батлагдсан. Үүнээс: 1. Шинээр-4 стандарт 2. Дахин хянасан -2 стандарт 3. Үндэсний болгосон 18 стандарт тус тус батлагдсан.
		13.4. Энэ хуулийн 13.2-т заасан бүтээгдэхүүний жагсаалт, тэдгээрийг	Захиргааны ерөнхий хуулийн 60-62-р зүйл болон Засгийн газрын 89 тогтоолын дагууЗасгийн газрын 2018 оны 10 сарын 03-ны өдрийн 291 тогтоолоор “Тохирлын

		<p>тохирлын баталгаатайгаар Монгол Улсын зах зээлд нийлүүлэх, хилээр нэвтрүүлэх журмыг Засгийн газар батална. /13.2.Тохирлын үнэлгээнд хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүнийг заавал хамруулна./</p>	<p>баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт"-ыг 1 дүгээр, "Тохирлын баталгаатай бүтээгдэхүүн, үйлчилгээг Монгол Улсын зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэх журам"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн батлуулсан.</p>
		<p>14.2. Монгол Улсаас олон улс, бүс нутгийн байгууллага, худалдааны түнш орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрээр тохирсон тохирлын болон түүнтэй адилтгах тэмдэг, гэрчилгээг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүлээн зөвшөөрнө.</p>	<p>Итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний 11 байгууллага Олон улсын лаборатори итгэмжлэлийн хамтын ажиллагааны ILAC MRA таних тэмдгийг үндэсний итгэмжлэлийн таних тэмдэгтэй хослуулан ашиглах гэрээ байгуулан эрдэс түүхий эд, мал эмнэлгийн чиглэлээр сорилтын үр дүнг гадны улс оронд хүлээн зөвшөөрүүлэн хэрэглэж байна. IAF MLA хамтарсан лого тэмдэг хэрэглэх тухай өргөдлийн маягт, гэрээний загварыг боловсруулж, СХЗГ-ын цахим хуудсанд байрлуулсан. Одоогийн байдлаар "Эс Эф Си Эс" ХХК (менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллага), "Монсертф" ХХК (менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллага), СХЗГ-ын Бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалтын газар (Менежментийн тогтолцоо ба бүтээгдэхүүний баталгаажуулалтын байгууллага) баталгаажуулалтын гэрчилгээнд үндэсний итгэмжлэлийн байгууллагын таних тэмдгийг IAF MLA тэмдэгтэй хослуулан хэрэглэж байна.</p>
		<p>14.5. Нийлүүлэгчийн мэдэгдэл гаргах журмыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.</p>	<p>Захиргааны ерөнхий хуулийн 60-62-р зүйл, Засгийн газрын 89 дүгээр тогтоолын дагуу СХЗГ даргын 2018 оны 07 сарын 24-ны А/257 тушаалаар "Нийлүүлэгчийн мэдэгдэл олгох журам" шинээр баталсан.</p>
		<p>14.9. Аюулгүйн тэмдгийн хэлбэр, хэмжээ, хэрэглэх журмыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.</p>	<p>Захиргааны ерөнхий хуулийн 60-62-р зүйл, Засгийн газрын 89 дүгээр тогтоолын дагуу "Аюулгүйн тэмдгийн журам" шинээр СХЗГ даргын 2018 оны 07 сарын 23-ны А/253 тушаалаар баталсан.</p>
		<p>19.2. Итгэмжлэлийг энэ хуулийн 19.1-д заасан байгууллага эрхлэн гүйцэтгэх бөгөөд итгэмжлэлийн байгууллагын дүрмийг Засгийн газар батална. /19.1.Итгэмжлэлийн байгууллага нь тохирлын үнэлгээний итгэмжлэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэд ажиллана./</p>	<p>Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 19-ны 270 дугаар тогтоолын 1-р хавсралтаар Монгол Улсын Шадар сайдын харьяанд Үндэсний итгэмжлэлийн төв байгуулахаар, тус тогтоолын 2-р хавсралтаар Үндэсний итгэмжлэлийн төвийн дүрмийг тус тус баталсан.</p>
		<p>30.4. Энэ хуульд заасан төлбөртэй ажил, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээг стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн</p>	<p>Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн хүрээнд дараах ажил үйлчилгээний төлбөр шинэчлэгдэн батлагдсан. Үүнд: 1. Баталгаажуулалтын ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээ, Шадар Сайдын 2019 оны 22 дугаар тушаал</p>

		асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.	2. Стандартчилал, тохирлын үнэлгээний ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээ, Шадар Сайдын 2019 оны 30 дугаар тушаал
9.	Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай 2018.06.27	10.10. Энэ хуульд заасан хувьцаанд хөрвөх хоёрдогч өглөг, давуу эрхийн хувьцааны нөхцөлийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанкны Ерөнхийлөгч хамтран баталсан журмаар тогтооно. 13.5. Төрөөс дахин хөрөнгөжүүлсэн банканд төрөөс оруулсан хөрөнгийг удирдах, хянах, төсөвт буцаан төвлөрүүлэхтэй холбогдох журмыг Монголбанкны саналыг үндэслэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.10-т заасны дагуу 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А-53/30 тоот дугаартай Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын тушаалаар “Дахин хөрөнгөжүүлсэн банкнаас гаргах хувьцаанд хөрвөх хоёрдогч өглөг, давуу эрхийн хувьцааны нөхцлийн журам”-ыг баталсан. Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А-53/30 тоот хамтарсан тушаалаар “Дахин хөрөнгөжүүлсэн банкнаас гаргах хувьцаанд хөрвөх хоёрдогч өглөг, давуу эрхийн хувьцааны нөхцөлийн журам”-ыг, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 17-н өдрийн 280 дугаар тушаалаар “Төрөөс дахин хөрөнгөжүүлэх банканд төрөөс оруулсан хөрөнгийг удирдах, хянах, төсөвт буцаан төвлөрүүлэх журам”-ыг тус тус баталсан.
10.	Хэмжил зүйн тухай /Шинэчилсэн найруулга/ 2019.05.09	5.1. Улсын эталоныг Засгийн газар, стандартчилсан загварыг хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална. 10.6. Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын лац, тэмдэг, гэрчилгээ, мэдэгдлийн загварыг хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална. 11.1. Хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 8.1-д заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, суурилуулах, засварлах үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын чадавхыг үнэлж, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэнэ.	Засгийн газрын тогтоолоор батлагдсан Хэмжлийн 7 төрлөөр улсын болон анхдагч эталоныг бий болгон үйл ажиллагаа явуулж байна. СХЗГ-ын Хэмжил зүйн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлагдсан нийт 77 төрлийн стандартчилсан загвар бүртгэлтэй байна. СХЗГ-ын даргын 2016 оны 5-р сарын 30-ны өдрийн №А/153 тоот тушаалаар баталсан “Гэрчилгээ, тооцоот баримтыг хэрэглэх, түүнтэй холбоотой харилцааг зохицуулах журам”-ыг мөрдөн ажиллаж байна. Хэмжил зүйн үйл ажиллагаа эрхлэхээр хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэгдсэн нийт 138 аж ахуйн нэгж байгууллага байна.
11.	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай /Шинэчилсэн найруулга/ 2019.06.06	11.5. Сангаас хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журмыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 14.6-д заасны дагуу Засгийн газар батална.	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн хүрээнд Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ыг батлуулав.
Нийт 11 хуулийн 39 хэсэг, заалт			

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД БҮРЭН ХЭРЭГЖСЭН,
ХЯНАЛТААС ХАСАХ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ /ХЭСЭГ, ЗААЛТ/-ЫН ЖАГСААЛТ
/2019 оны жилийн эцсийн байдлаар/**

№	Тогтоолын нэр, огноо	Заалтын агуулга	Хэрэгжилт
1.	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай 2015.06.11 №52	5.3. Төрийн байгууллагуудын ажлын хариуцлагыг дээшлүүлэх, төрийн албаны шат бүрд ажлын гүйцэтгэл, үр дүнг тогтмол үнэлдэг тогтолцоог бий болгох.	Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоол, ЗГХЭГ-ын даргын 2019 оны 47 дугаар тушаалаар ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлж байна.
2.	Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай 2015.06.19 №62	2.1/ Бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги хөтөлбөрийг таван жилээр төлөвлөж, холбогдох төлөвлөгөө, төслийг боловсруулан баталж, хэрэгжилтийг үе шаттайгаар зохион байгуулах.	Засгийн газрын 2015.10.05-ны өдрийн 396 дугаар тогтоолоор Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги /2015-2020/-ыг баталсан бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ХХААХҮ, УУХҮ-ийн сайдын хамтарсан 2018 оны А-79/А/93 дугаар тушаалаар “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г батлуулан ажиллаж байна. Үйлдвэрлэл, худалдааг дэмжих эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр ЗГ-ын 2019 оны 156 дугаар тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр”, ЗГ-ын 2019 оны 190 дүгээр тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих тэргүүлэх чиглэл”-ийг тус тус батлуулсан. Мөн ЗГ-ын 418 дугаар тогтоолоор “Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих хөтөлбөр”, 362 дугаар тогтоолоор “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр”-ийг тус тус батлуулсан. “Үйлдвэржилт 21:100”, “Ноолуур” хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувь 33.3%, арьс ширэн түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин 33.1%, ноос, ноолууран түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин 26%-иар тус тус өссөн дүнтэй байна. Оёмол бүтээгдэхүүн, хувцас үйлдвэрлэгчдийн 2019 онд зохион байгуулсан зөвөлгөөнөөс гарсан санал, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, 2020-2025 онд Оёдлын салбарыг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан 2020 онд батлуулахаар ТНБД-ын 2020 оны А-57 дугаар тушаалаар Оёдлын салбарыг хөгжүүлэх хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Оёдлын салбарын нөхцөл байдлын судалгаа, шинжилгээ зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох төндөр зарлан шалгаруулалт явагдаж байна. Урьдчилсан байдлаар салбарын нөхцөл байдлын шинжилгээний төсөл боловсруулан, ажлын хэсгийн гишүүдээс санал авч хөтөлбөрийн зорилго, зорилтыг тодорхойлон зорилтуудыг хэрэгжүүлэх бодлогын хувилбаруудыг боловсруулж, санхүүжилтийн эх үүсвэрийн тооцоолол нөлөөллийн үнэлгээ зэргийг гүйцэтгэж хөтөлбөрийн төслийг боловсруулж байна. Тус бодлогын /дунд хугацааны стратеги/-д тусгагдсан ХХААХҮ-ийн салбарт хамаарах 6 зорилтын 24 арга хэмжээний 2019 оны хэрэгжилтийн ерөнхий дундаж үнэлгээ 77.1 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” байна.

		<p>2.3/ Энэ тогтоолын 2 дахь заалтын 1-д заасан стратеги хөтөлбөр, төлөвлөгөө, төслийг Монгол Улсын жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлэх.</p>	<p>Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016, 2017, 2018, 2019, 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд төмөр, зэс, тэдгээрээр хийсэн бүтээгдэхүүн, нүүрс боловсруулах үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлж, газрын тос боловсруулах, зэс хайлуулах, алт цэвэршүүлэх үйлдвэрүүдийг барьж байгуулах зорилтуудыг тусган ажиллаж байна.</p> <p>Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд хөнгөн үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний зардалд 495,0 орчим сая төгрөгийг тусгуулсан. -“Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлж, үйлдвэржүүлэх бодлого хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хүрээнд 65,0 тэрбум төгрөгийг Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, 56,3 сая долларыг ЕСБХБ-ны хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлэхээр тусгасан. -Ноолуур” хөтөлбөр хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хүрээнд 500,0 тэрбум төгрөгийг Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэхээр тусгасан.</p>
		<p>2.4/ Дунд, урт хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, бүтээмж болон өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны ангиллын дагуу гаргасан албан ёсны статистик үзүүлэлтэд үндэслэн бодлогын хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгч, шаардлагатай арга хэмжээг авах.</p>	<p>Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны ангиллын дагуу гаргасан албан ёсны статистик үзүүлэлтэд үндэслэн бодлогын хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгч түүний мөрөөр төсөв, санхүүжилтийн тооцоо, судалгаа, танилцуулгыг нэгтгэн гаргаж жил бүрийн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгуулан ажиллаж байна.</p> <p>“Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-ыг боловсруулж Засгийн газрын 2015.10.05-ны өдрийн 396 дугаар тогтоолоор батлуулсан. Хэрэгжилтийг хангахаар “Дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулан ХХААХҮ болон УУХҮ-ийн сайдын А79/А93 дугаартай хамтарсан тушаалаар батлуулсан. Статистик мэдээллийн бодит болгох ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд ҮСХ-той хамтран Хөнгөн үйлдвэрийн салбарын статистик мэдээллийн өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудал сэдэвт сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулав. Мэдээллээ нарийвчлах, судалгааны арга аргачлалыг боловсронгуй болгох чиглэлээр 2 тал хамтран ажиллахаар тохиров. Үйлдвэржилтийн мэдээллийн нэгдсэн сан болон үйлдвэржилтийн бүсчилэлийн асуудлаар ҮХГ-тай хамтран ажиллаж, зарим судалгааг хамтран боловсруулж байна. Яамны Бодлого төлөвлөлтийн газрын мэдээллийн сан хариуцсан мэргэжилтнээр дамжуулан ҮСХ-ноос авах мэдээллийн ерөнхий загварыг гаргаж, хүргүүлэв.</p>
3.	<p>Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2016.04.14 №34</p>	<p>1.3. Газар хөдлөлтөөс хамгаалах арга хэмжээг хот төлөвлөлтийн бодлогод тусгаж хэрэгжүүлэх, төвлөрлийг сааруулж, суурьшлын бүс, дагуул хотыг газар хөдлөлтийн эрсдэл багатай бүс рүү төлөвлөж хөгжүүлэх арга хэмжээг авах.</p>	<p>Мөн энэ арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд хууль эрх зүйн орчны шинэчлэл хийгдэж байгаа бөгөөд Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд гамшиг, газар хөдлөлийн талаар тодорхой зүйл, заалтуудыг тусгасан. Улаанбаатар хотын 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагад бүсийн хүн амыг 2030 онд 1763.0 мян байхаар мөн дагуул хот, тосгодын хүн ам 171.5 мянга болж өсөхөөр тооцоолж Багануур, Багахангай, Оюутны хотхон (шинэ хот), Аэросити (шинэ хот) зэрэг дагуул хот, тосгодыг тодорхой чиглэлийн үйлдвэр, худалдаа үйлчилгээ дагнан хөгжүүлэхээр тусгасан. Үүний дагуу Багануур хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.</p>
4.	<p>Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд</p>	<p>3.1. Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дунд хугацааны үндэсний хөтөлбөрийн хүрээнд</p>	<p>Хууль тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлтийг танилцуулах, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандартыг сурталчлах, олон улсын туршлага судлах, холбогдох байгууллагуудын ажлын уялдааг сайжруулах чиглэлээр сургалт,</p>

	<p>баримтлах үндсэн чиглэл батлах тухай 2017.11.16 №70</p>	<p>зохион байгуулах ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөөг 2018 оны 01 дүгээр сард багтаан баталж хэрэгжүүлэх, эрх зүйн орчныг олон улсын байгууллагаас тогтоосон стандарт, зөвлөмжтэй 2018 оны 07 дугаар сард багтаан нийцүүлж, хэрэгжилтийг 2018 оны 10 дугаар сараас өмнө хангах.</p>	<p>семинар тогтмол зохион байгуулж, албан хаагчдыг мэргэшүүлэхэд анхааран ажиллав. АХБ-тай Монголбанкны Санхүүгийн мэдээллийн алба (СМА) хамтран хууль сахиулах байгууллагуудын мөнгө угаахтай тэмцэх чадавхийг дээшлүүлэх, шүүхийн байгууллагуудын чадавхийг сайжруулах, харилцагчийг таньж мэдэх, эрсдэлд суурилсан чадамжийг бэхжүүлэх хөтөлбөр сэдэвт сургагч багш бэлтгэх сургалтуудыг зохион байгуулав. Австрали Улсын Дотоод хэргийн яамны үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх болон хориг арга хэмжээ хэрэгжүүлэх чиглэлээр техник туслалцаа авч ажиллаж байгаа бөгөөд техник туслалцааны хүрээнд яамд, хууль сахиулах байгууллагууд болон гаалийн байгууллагын албан тушаалтнуудад зориулсан сургалтыг зохион байгуулав. Арилжааны банк, хянан шалгагчид, валют арилжаа болон үл хөдлөх хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын ажилтнуудад зориулсан Монгол Улсын харилцагчийг таньж мэдэх журам болон олон улсад мөрдөгдөж буй стандарт, хэрэгжүүлж буй арга хэмжээ сэдэвт сургалтуудыг тогтмол зохион байгуулж байна. АНУ-ын Сангийн яамны харьяа Санхүүгийн тагнуулын албанаас үзүүлж байгаа техник туслалцааны хүрээнд СМА-д ажиллаж байгаа зөвлөх Татварын ерөнхий газрын албан хаагчдад мөнгө угаах гэмт хэрэг, тэдгээрийг мөрдөн шалгах орчин үеийн чиг хандлагын талаар сургалт зохион байгуулав. 2019 онд нийт 5 удаагийн сургалтыг зохион байгууллаа. Үүнд: "Терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхтэй тэмцэх" сэдэвт олон улсын бүсийн сургалтыг НҮБ болон хууль сахиулах байгууллага, СМА-тай хамтран 9 дүгээр сар болон 11 дүгээр сард 2 удаа, Шүүгч нарт "Монгол Улс дахь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо, түүний үйл ажиллагаа" сэдэвт сургалтыг 7 дугаар сард, олон нийт болон сэтгүүлч нарт зориулан "Монгол Улс дахь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо, түүний үйл ажиллагаа" сэдэвт сургалтыг 6 дугаар сард, Банкны холбооны комплаенс, эрсдэл хариуцсан ажилтнуудад зориулан "Мөнгө угаах тогтолцоо" зэрэг сэдэвт сургалтыг зохион байгуулж, оролцлоо. Мөн ФАТФ-аас гаргасан олон улсын стандарт 3 баримт бичгийг, НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан 2 тогтоолыг монгол хэлэнд орчуулан хуралд оролцогчдод хүргүүлсэн. Терроризмыг санхүүжүүлэх, үйл олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх тогтолцоо сэдэвт үндэсний сургалтыг 2019.11.13-15-ны өдрүүдэд НҮБ-ын UNODC-тэй хамтран зохион байгуулж, уг сургалтад дотоодын төрийн байгууллагууд болон шүүхийн шүүгчид оролцсон.</p>
	<p>3.2. санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлэх.</p>	<p>Засгийн газрын 2017 оны 299 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Хөтөлбөрийн хэрэгжилтийг 2019 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн дүгнэхэд бүрэн биелсэн 43 арга хэмжээ, хэрэгжих шатандаа 45 арга хэмжээ, нийт хэрэгжилт 84 хувьтай бөгөөд хөтөлбөр нь 2025 он хүртэл хэрэгжих болно.</p>	
	<p>3.3. банкны салбарын бүтцийн өөрчлөлтийн дэд бүтцийг бэхжүүлж, түүний эрх зүйн орчинг боловсронгуй</p>	<p>Банкны салбарын бүтцийн өөрчлөлтийн дэд бүтцийг сайжруулах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох хүрээнд Банкны салбарт томоохон хууль, эрх зүйн шинэчлэлийг амжилттай хийж, хэрэгжүүлж чадсан байна. Тухайлбал, Төвбанк /Монголбанк/-ны тухай</p>	

		болгох.	хуулийн нэмэлт өөрчлөлт, Банкны тухай хуулийн шинэчилсэн найруулга, Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчлэн найруулгын төслийг болон Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуулийг шинээр УИХ-аар баталсан байна.
5.	Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2017.12.21 №87	1.1. хүчин төгөлдөр үйлчилж байгаа үндэсний стандартын баримт бичгийн үзлэгийг зохион байгуулж, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хангах, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн техникийн зохицуулалтын баримт бичгийг боловсруулж, батлах. 1.2. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасан дүрэм, журмыг 2018 оны 3 дугаар улиралд багтаан шинээр болон шинэчлэн батлах.	УИХ-ын 87 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Сайдын 97 дугаар захирамжын дагуу Монгол улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөж байгаа нийт 6216 стандартад шинжлэх ухаан техникийн түвшинд улсын үзлэг зохион байгуулж 367 стандартыг хүчингүй болголоо Мөн 2074 стандартыг дахин хянаж шинэчлэх, 591 стандартыг шинээр боловсруулахаар ажилаж байна. Монгол улсад цаашид шаардлагатай салбар бүрийн 18 Техникийн зохицуулалтыг боловсруулах жагсаалтыг Засгийн газрын 2019 оны 235 тогтоолоор батлуулсан. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд зааснаар стандартчилал, тохирлын үнэлгээ, итгэмжлэлийн үйл ажиллагаатай холбоотой 25 дүрэм, журам шинээр болон шинэчлэгдэн батлагдсан.
6.	“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” 2018.05.24 №37	2. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хууль, бодлогын бусад баримт бичиг, хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монголбанк /Н.Баяртсайхан/, Санхүүгийн зохицуулах хороо /С.Даваасүрэн/ болон холбогдох бусад байгууллагад үүрэг болгосугай. 3. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийг оны эхнээс жигд ханган зохион байгуулж, биелэлтийг бүтэн жилээр гаргаж, Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай.	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд нийт 135 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлснээс 79 арга хэмжээг “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-тай, 125 арга хэмжээг Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй, 27 арга хэмжээг Төрөөс баримтлах бодлоготой, 6 арга хэмжээг бусад бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан хэрэгжүүлсэн байна. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд тусгагдсан 5 бодлого, 20 зорилт, 135 арга хэмжээний хэрэгжилт 2019 оны жилийн эцсийн байдлаар 78.0 хувьтай гарлаа. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д Макро эдийн засгийн бодлого, Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого, Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого, Хүний хөгжлийг дэмжих нийгмийн салбарын бодлого, Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого гэсэн нийт 5 бүлэг, 20 зорилт, 135 бодлогын арга хэмжээг тусган, оны эхнээс жигд зохион байгуулж хэрэгжүүллээ. Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д нийцүүлэн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.

			Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн 5 бодлого, 20 зорилт, 135 арга хэмжээний хэрэгжилт 2019 оны жилийн эцсийн байдлаар 78.0 хувьтай гарлаа. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн жилийн эцсийн биелэлтийг ЗГХЭГ-аас Улсын Их хуралд танилцуулахаар өргөн мэдүүлсэн. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг Улсын Их Хурлын ЭЗБХ-ны 2020.04.28-ны хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтлоо.
7.	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай 2018.11.15 №84	1/ Монгол Улсаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр авсан арга хэмжээнд олон улсын байгууллагаас хийсэн үнэлгээг дээшлүүлэх шат дараалсан арга хэмжээг төрийн эрх бүхий байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх;	Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-аар 2019.10.10-ны өдөр батлуулсан. Уг хуулийн төсөлтэй хамт нийт 7 хуульд нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан тогтоолыг хэрэгжүүлэх, дотоодын болон олон улсад террорист этгээдээр зарлагдсан этгээдийн нэгдсэн жагсаалттай болох, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх төрийн бодлогын нэгдсэн байдлыг хангах, үй олноор болон хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмоос урьдчилан сэргийлэх, террорист үйлдлийг таслан зогсоох, үйл ажиллагааны зарчим, үндсэн чиглэл, зохион байгуулалтыг үндсийг тогтоох зэргийг хуульчлан олон улсын жишигт нийцэх хуулийн төслийг боловсруулж батлуулсан. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого болон Үндэсний эрсдэлийн үнэлгээ боловсруулах чиглэлээр гадаад улсаас техник тусламж, зээл авах шаардлагатай гэж үзэн Санхүүгийн мэдээллийн албаны дэргэдэх Хамтын ажиллагааны зөвлөлөөс донор байгууллагуудын уулзалтаар хүсэлт тавив. Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороотой хамтарсан ажлын хэсэг 14 багийн бүрэлдэхүүнтэй нийт 46 байгууллагад 2019.01.22-ноос 2 дугаар сарын 24-ний өдрийг дуустал хугацаанд шалгалт хийж гүйцэтгэсэн. Монголын банкны холбоо, арилжааны банкуудын төлөөлөлтэй хамтран Хамтын ажиллагааны зөвлөлийн дэргэдэх хяналт шалгалтын дэд ажлын хэсгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажиллаж байна. Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Монголын хуульчдын холбоо, ХЗДХЯ, Сангийн яам болон Монголын нотариатчидын холбоотой хамтран цахим орчинд харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг ФАТФ-ын 40 зөвлөмжид нийцтэйгээр хэрэгжүүлэх боломжийг судлах ажлын хэсгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж байна. Судалгаа сургалт, эдийн засгийн хүрээлэнтэй хамтран бүх банкны комплаенсийн мэргэжилтнүүдэд “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа ” сэдвээр 2019.09.25-ны өдөр сургалт зохион байгуулсан. “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний стратеги”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор УИХ 2019.10.10-ны өдөр батлагдсан “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтэй тэмцэх тухай” хуультай хамтатгаж санхүүгийн бус бизнес болон мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчд (СББМҮҮ)-ийн хяналт шалгалтыг хийх, мөнгө угаахтай тэмцэх чиглэлийн эрсдэлийг зохицуулах байгууллагуудыг тодорхойлж, холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлтийг хийсэн. Ингэснээр санхүүгийн бус бизнес болон мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийг нэгдсэн хяналт шалгалтын тогтолцоотой болгох, зохицуулагч байгууллага болон СББМҮҮ нарыг мөнгө угаахтай тэмцэх чиглэлээр сургах, энэ төрлийн гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах боломж бүрдэж байна. Цагдаагийн байгууллагаас 2019 онд Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар

		<p>зүйлд заасан Мөнгө угаах гэмт хэргээр нийт 130 хэрэг бүртгэлтийн хэрэг нээж мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байна. Үүнээс 60 хэрэг бүртгэлтийн хэргийг хааж, 2 хэргийг хэрэгсэхгүй болгож, 4 хэргийг түдгэлзүүлж, одоо үлдэгдэл 42 хэрэг бүртгэлтийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагааг явуулж байна. Мөн 51 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж, 35 хэргийг хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт хүргүүлж, одоо 16 эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна. Мөн Ашгийн бус хуулийн этгээдийн тухай хуулийн төслийг ХЗДХЯ-аас боловсруулж, холбогдох байгууллагаас саналыг авч, 2019.09.25, 10 дугаар сарын 15-ны өдрүүдэд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсон.</p>
	3/ зээлийн хүүг бууруулах стратегийн хэрэгжилтийг хангах;	<p>Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2018.06.12-ны өдрийн А-167/139/399/37 дугаар хамтарсан тушаалаар “Зээлийн хүү бууруулах стратеги 2018-2023”-ийн стратегийн баримт бичгийг баталсан. Тус баримт бичгийн зорилт нь зээлийн хүүг бууруулах бөгөөд түүнийг хэрэгжүүлэхэд макро эдийн засгийн орчинг бүрдүүлэх, бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх, банкуудын эрсдэл даах чадвар, үр ашиг болон засаглалыг сайжруулснаар зээлийн хүүг бууруулна. Зээлийн хүүг бууруулах стратегийн арга хэмжээний хэрэгжилтийн биелэлтийг хагас жил болон жилийн эцсийн байдлаар бэлтгэн Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлын албанд хүргүүлж, цаашид УИХ-ын холбогдох байнгын хороонд тайлагнадаг. Тус стратегийн биелэлтийг 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар Монголбанкинд 2020.04.20-ны 8-1/2590 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p>
	4/ чанаргүй активыг бууруулах стратегийн хэрэгжилтийг хангах;	<p>Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2018.06.12-ны өдрийн А-168/140/400/38 дугаар хамтарсан тушаалаар “Чанаргүй активыг бууруулах стратегийн баримт бичиг”-ийг батлаад байна. Тус стратегийн нэг зорилго нь банк төдийгүй иргэн, хуулийн этгээд, төр болон бусад зээлдүүлэгчийн зардлыг бууруулах замаар зээлийн хүү буурах нөхцөлийг бүрдүүлэх, зээл олголтыг нэмэгдүүлэх, иргэд, байгууллагын бизнесийн орлогыг нэмэгдүүлэх, улмаар эдийн засгийн өсөлтийг дэмжих юм. Стратегийн баримт бичгийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4-8 дугаарт заасан Шийдвэр гүйцэтгэлийн шатанд байгаа саад бэрхшээлийг арилгах, Үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, барьцааны бүртгэлийн асуудал, Татварын зохицуулалтыг бий болгох, Дампуурлын асуудал болон Шүүхийн бус журмаар үүргийн гүйцэтгэлийг хангуулах зэрэг чиглэлээр тусгагдсан тодорхой ажлуудыг Сангийн яам болон бусад байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байна. Тухайлбал, Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, дагаж гарах хуулийн төслүүдийг Хууль тогтоомжийн хуульд заасны дагуу хуулийн үзэл баримтлалыг боловсруулж, холбогдох судалгаа, олон нийтийн саналыг авч эцэслэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлээд байна.</p>
	6/ санхүүгийн салбарыг дэмжиж, тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах;	<p>Засгийн газрын 2017 оны 299 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Хөтөлбөрийн хэрэгжилтийг 2019 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн дүгнэхэд бүрэн биелсэн 43 арга хэмжээ, хэрэгжих шатандаа 45 арга хэмжээ, нийт хэрэгжилт 84 хувьтай бөгөөд хөтөлбөр нь 2025 он хүртэл хэрэгжих болно.</p>

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ
ТОГТООЛ /ХЭСЭГ, ЗААЛТ/-ЫН ЖАГСААЛТ
/2019 оны жилийн эцсийн байдлаар/**

№	Тогтоолын нэр, огноо	Заалтын агуулга	Хэрэгжилт
1.	Монгол Улсын өмнөд бүсийн ашигт малтмалын томоохон орд газруудад шаардагдах дэд бүтцийн хөгжлийн стратегийг тодорхойлох тухай 2009.11.03 №44	<p>2.1. Улаанбаатар-Мандалговь-Тавантолгой-Оюутолгой-Цагаан суварга чиглэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам барьж байгуулах;</p> <p>2.2. Өмнөд бүсийн нутаг дэвсгэрт явуулсан гидрогеологийн хайгуул, судалгааны ажлын үр дүнд тогтоогдсон Галбын говь, Гүний хоолой, Балгасын Улаан нуурын доорхи усны нөөцийг үйлдвэрлэлийн чиглэлээр ашиглах</p>	<p>Оюутолгой-Цагаан суварга чиглэлийн агаарын шугам, дэд станц төсөл/ Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих/:</p> <p>Засгийн газрын 2016 оны 148 дугаар тогтоолын дагуу концессын гэрээг Монголын алт (МАК) ХХК-тай 2017 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр байгуулсан. 2017 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн ЭХХТ-170/08/2017 дугаар техникийн комиссын акт, мөн "Цагаансуварга-Оюутолгой" 220кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 220/22 кВ-ын дэд станцын барилга байгууламжийг ашиглалтад оруулах 2017 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн техникийн комиссын актыг ирүүлсэн. Техникийн комиссоос нэмэлтээр реактор суурилуулах даалгавар өгсөн.</p> <p>"Монголын Алт" (МАК) ХХК-ийн зүгээс нэмэлт реактор суурилуулах ажлыг 2019 оны 11 дүгээр сард дуусгаж, улсын комисст хүлээлгэн өгөх гэсэн боловч Эрчим хүчний хөгжлийн төвөөс манай газарт ирүүлсэн 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 1/1662 дугаартай "Концессын гэрээний хэрэгжилтийн тухай" албан бичигт "...2019-2020 оны халаалтын улирал эхэлсэнтэй холбогдуулан Тавантолгой, Оюутолгой, Цагаансуварга дэд станцуудыг шинээр 220 кВ-ын түвшинд шилжүүлэх зохион байгуулалтын ажил хойшлогдож, 2020 оны 5 дугаар сараас эхлэн үе шаттайгаар хийгдэж Цагаансуварга дэд станцыг 220кВ-ын хүчдэлд залгах техникийн боломж бий болсноор туршилт, тохируулга хийгдэж, улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад хүлээн авах бөгөөд энэ нь концесс эзэмшигчээс шалтгаалахгүй болно..." гэж дурдсан байна. Улсын комисст хүлээлгэн өгөх ажил хүлээгдэж байна.</p> <p>Уг төслийн хүрээнд нийт 249 км 330 кВ-ын ЦДАШ-ын урсралтын ажил 100%, Мандалговь, Тавантолгой, Оюутолгойн 220 кВ-ын дэд станцын барилга угсралтын ажлууд 100% хийгдэж дуусан төслийн ажлыг 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр хүлээлгэн өгсөн. Нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас хэрэгжүүлж буй Сонгино дэд станцын барилга угсралтын ажил гэрээний хугацаандаа хийгдээгүй хүлээгдэж байгаагаас болж БНХАУ-ын зээлээр хэрэгжсэн дээрх шугам, дэд станцын ажилд бүрэн хэмжээний хүчдэл өгч турших боломжгүй байна. Сонгино дэд станцын төслийн нийт барилга угсралтын ажил 95 орчим хувьтай хэрэгжиж байна.</p> <p>Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших Галбын говийн газрын доорх усны нөөцийг нарийвчлан тооцож, үйл ажиллагаа явуулахад Тусгай хамгаалалттай газар нутгийн хуулийн дагуу уул уурхайд ашиглах боломжгүй,</p> <p>Гүний хоолойн газрын доорх усны ордод 2015 онд усны нөөцийг дахин үнэлж, газрын доорх усны ашиглалтын хайгуулын ажил хийгдэж, усны нөөцийг 918 л/с-ээр, Балгасын улаан</p>

		тооцоог нарийвчлан үзэж шийдвэрлэх;	нуурын газрын доорх усны орд нь говийн бүсийн цэнгэг усны орд учраас Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын дагуу уул уурхайд ашиглуулахыг хориглосон, усны нөөцийг 2014 онд дахин тооцож 404,3 л/с-ээр тус тус тооцож тогтоосон.
		2.3. Улсын төсвийн хөрөнгө болон эргэн төлөгдөх нөхцөлөөр Улаанбаатар-Мандалговь, Мандалговь-Даланзадгад, Даланзадгад-Тавантолгой-Оюутолгой, Оюутолгой-Гашуунсухайт, Нарийн сухайт-Шивээхүрэн чиглэлийн хатуу хучилттай авто замыг барих ажлыг эхлүүлэх;	Улаанбаатар-Мандалговь, Мандалговь-Даланзадгад, Даланзадгад-Тавантолгой-Оюутолгой, Оюутолгой-Гашуунсухайт, Нарийн сухайт-Шивээхүрэн чиглэлийн хатуу хучилттай авто замыг 2014-2016 онуудад тус тус байнгын ашиглалтад оруулсан.
		2.4 Шивээ-Овоо, Тавантолгойн орд газарт эрчим хүчний шинэ эх үүсвэр барьж байгуулах ажлыг шийдвэрлэх;	1.Тавантолгойн цахилгаан станцыг Төрийн өмчийн хэлбэрээр хэрэгжүүлэх тухай Засгийн газрын 2020 он 04 дүгээр сарын 08-ний өдрийн 124 дүгээр тогтоол гарсан. Уг тогтоолын дагуу Эрчим хүчний сайдын тушаалаар ажлын хэсэг байгуулан станц барих бэлтгэл ажлыг хангуулахаар ажиллаж байна. 70% 2.Эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг 2018-2020 оны түвшинд хангахад Багануур, Шивээ-Овоогийн уурхайн найдвартай, хэвийн үйл ажиллагааг тасралтгүй хангах, хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник, технологийн шинэчлэл зайлшгүй хийхэд шаардагдах хөрөнгө оруулалтын тооцоо, судалгааг гаргасан. Яамдаас авсан саналыг нэгтгэж Засгийн газрын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажилласан. Монгол Улсын засгийн газрын 2019 оны 10 дугаар сарын 2-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр Багануур,Шивээ -овоогийн уурхайн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, Засгийн газрын 2018 оны 132 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар Монгол Улсын сайд,Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэ Засгийн газрын гишүүдэд танилцуулсан бөгөөд Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг түшиглэн 100-150 МВт-ын дулааны цахилгаан станц байгуулах асуудлыг судлан үзэж эдийн засгийн хувьд үр ашигтай болох нь тогтоогдвол холбогдох ТЭЗҮ-г боловсруулж танилцуулахыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал П.Ганхүүд даалгажээ.
2.	Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2010.06.08 №16	1.1. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр барьж байгуулахаар 2007 онд “Түлхүүр гардуулах нөхцөлөөр шууд гэрээ” байгуулсан гүйцэтгэгчидтэй гэрээгээр хүлээсэн үүргийнх нь дагуу баталгаат хугацаандаа ашиглалтын үйл ажиллагаанаас үл хамаарч эвдэрсэн тоног төхөөрмжүүдийг 2010 оны 8 дугаар сарын 01-ний дотор сэргээн засварлаж хэвийн ажиллагаанд оруулах, эсхүл нарны цахилгаан станц барьж ашиглалтад өгөх талаар тохиролцох, хохирлыг арилгах зэрэг арга хэмжээ авах;	6 аймгийн 8 суманд 100-150МВт-ын нар болон нар салхиний хосоллосон станцийг ашиглалтад оруулж холбогдох түгээх компаниудын өмчлөлд шилжүүлсэн 2020 оны 01 дүгээр улирлын байдлаар заалтад дурдсан бүх сумдууд нэгдсэн сүлжээнд холбогдсон бөгөөд тус эх үүсвэрүүдийг сум тус бүрийн багуудад шилжүүлсэн.
		1.2. Баянхонгор аймгийн Баянцагаан, Баян-Өндөр, Шинэжинст, Өмнөговь аймгийн Манлай, Говь-Алтай аймгийн	2020 оны 01 улирлын байдлаар эдгээр сумдууд төвлөрсөн эрчим хүчний системд холбогдсон.

		<p>Цээл, Дорноговь аймгийн Хатанбулаг, Мандах сумдад Азийн хөгжлийн банк болон БНСУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 100-150 квт-ын хүчин чадалтай нарны цахилгаан станц шинээр барих, Өмнөговь аймгийн Сэврэй, Өвөрхангай аймгийн Богд, Дорнод аймгийн Матад сумдыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 15 кв-ын цахилгаан дамжуулах агшаарын шугам татаж, төвлөрсөн эрчим хүчний системд холбох замаар 2010-2011 онд багтаан байнгын цахилгаанаар хангах арга хэмжээ авах;</p>	
		<p>1.3. Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаад, дотоодын зээл, тусламжийн хөрөнгөөр байгуулсан сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг өмчлөх, ашиглах, үйлчилгээ, борлуулалт хийх эрхийг Концессын хуулийн дагуу гэрээгээр аж ахуйн нэгжид, эсвэл тухайн орон нутгийн эрчим хүчний тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжид хариуцуулах асуудлыг шийдвэрлэх;</p>	<p>2020 оны 01 дүгээр улирлын байдлаар Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаад, дотоодын зээл, тусламжийн хөрөнгөөр барьж байгуулсан сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг өмчлөх, ашиглах, үйлчилгээ, борлуулалт хийх эрхийг ашиглалтад хүлээж авсны үндсэн дээр Холбогдох хууль дүрэм журмын хүрээнд аж ахуйн нэгжид эсвэл тухайн орон нутгийн эрчим хүчний тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжид хариуцуулах асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна.</p>
		<p>1.4. Сэргээгдэх эрчим хүчний объектуудыг хэвийн ажиллагаанд оруулах ажлыг хөрөнгө санхүү, эдийн засгийн хувьд чадвартай, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр угсарч суурилуулах туршлагатай мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авах;</p>	<p>Засгийн газрын 2008 оны 64 дүгээр тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эрчим хүчний газар байгуулснаар сэргээгдэх эрчим болон эрчим хүчний эх үүсвэр барьж байгуулах тусгай зөвшөөрлийг уг агенлагаас өгдөг болсон. Агентлаг нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр барьж байгуулах компаниудыг шалгаруулахдаа Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 16 тоот тогтоолыг мөрдөж ажиллахыг удирдамж болгож ажиллаж байсан бөгөөд 2009 оноос “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ байгуулагдаж сэргээгдэх эрчим хүчний объектуудыг хэвийн ажиллагаанд оруулах, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр угсарч суурилуулах, судалгаа хийх, төсөл хөтөлбөр боловсруулах гэх мэт жил ирэх бүр сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа нь өргөжин ажиллаж байна.</p>
		<p>1.5. Хөдөө орон нутгийн нийгэм, эдийн засгийн байдал, иргэдийн төлбөрийн чадварыг харгалзан хэрэглэгчдийг байнгын эрчим хүчээр хангах үүднээс сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг дизель цахилгаан станцтай хослон ажиллуулах үеийн цахилгаан эрчим хүчний үнэ, тарифыг тогтоож улсын төсвөөс зохих дэмжлэг үзүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх;</p>	<p>2020 оны 01 дүгээр улирлын байдлаар 21 аймгийн 329 сум цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон. Говь-Алтай аймгийн Алтай сум нь дизел станцаар ажиллаж байгаа бөгөөд улсын төсвөөс зохих дэмжлэгийг үзүүлэн ажиллаж байна.</p>
		<p>1.7. Монгол Улсад томоохон хүчин</p>	<p>Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ нь Монгол Улсад томоохон хүчин чадалтай</p>

		чадалтай нар салхи, усан цахилгаан станц барьж байгуулах талаарх судалгааны ажлыг эрчимжүүлэх, энэ талаар төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээс хийж буй судалгааны ажлыг дэмжиж, хамтран ажиллах.	нар салхи, усан цахилгаан станц барьж байгуулах талаарх судалгааны ажлыг хийх, энэ талаар төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээс хийж буй судалгааны ажлыг дэмжих үйл ажиллагааг Эрчим хүчний яамтай хамтран хэрэгжүүлэн ажиллаж байна.
3.	Авто зам, гүүрийн барилга угсралтын ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай 2011.11.23 №23	<p>1.3. Авто зам, гүүрийн даацыг нэмэгдүүлж, хүчитгэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч, хөдөлгөөний эрчим багатай, хөнгөвчилсөн хучилттай авто замаар явах ачааны автомашины даацын дээд хязгаарыг тогтоох, хатуу хучилттай авто замын баталгаат засварын хугацааг 2012 оны 01 дүгээр сарын 01-нээс 2 жилээр тооцож байх журамд шилжих.</p> <p>1.4. Шинээр авто зам барих ээлж дарааллыг тогтоохдоо улс, салбарын хөгжлийн бодлого, бодит хэрэгцээ шаардлага, тухайн замын хөдөлгөөний эрчим, ачаа урсгал, нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийг нарийвчлан тооцож жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлэх арга хэмжээг 2012 оноос эхлэн авч хэрэгжүүлэх.</p>	<p>Улсын болон орон нутгийн чанартай авто замаар зорчих тээврийн хэрэгслийн тэнхлэгийн ачааллын хэмжээг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандарт, нормын дагуу зураг төсөл боловсруулах, барих, ашиглахад мөрдөж байна. Олон улс, улсын чанартай авто замд автотээврийн хяналт тавих, төлбөр авах цэгийн барилга байгууламжийг үе шаттайгаар байгуулж байна. 2019 онд 3 цэг байгуулагдсан бол 2020 он 11 цэг шинээр барихаар ажиллаж байна. Мөн өмнө нь ажиллаж байсан 5 цэгт авто пүү суурилуулна. Авто замын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар авто замын барилгын баталгаат засварын хугацааг 3 жил байхаар тусган баталсан. Хуулинд өөрчлөлт оруулж, баталгаат засварын хугацааг 3 жилээр тогтоосон.</p> <p>Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн дагуу зам барилгын ажил гүйцэтгэх эрэмбийг тодорхойлон гаргаж, Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсаны дагуу 2013-2016 онд ашиглалтанд оруулах замын чиглэлийг тогтоож Засгийн газрын 143 тоот тогтоолоор баталгаажуулсан. Эхний ээлжинд бүх аймгийн төвүүдийг нийслэлтэй холбохоор шийдвэрлэсэн.</p> <p>Шинээр зам барих ажлыг тусгахдаа тухайн замын техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулан үүний үндсэн дээр зам барих ээлж дараалал, нарийвчилсан зураг төслийг боловсруулж байна. “Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн дагуу баригдах 5572км авто замд урьдчилсан техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн болно. Тухайн дунд хугацааны зорилтот хөтөлбөр 2016 онд хэрэгжиж дууссан.</p> <p>Монгол Улсын Засгийн газар 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөртөө олон улс, хот хоорондын болон орон нутгийн чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын сүлжээг өргөтгөж, бүх аймгийн төвийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбож дуусгах, Мянганы замын хэвтээ тэнхлэгийн хэсгийг үргэлжлүүлэх зорилт дэвшүүлэн томоохон бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлж байна. Энэхүү зорилтын хүрээнд 2016-2019 онд улсын хэмжээнд нийт 1773.33 км хатуу хучилттай авто зам, 2427.0 у/м төмөрбетон гүүрийг барьж улсын ашиглалтад оруулсан бөгөөд эдгээр төслүүд хэрэгжиж дууссанаар нийт 17 аймгийн төв, 95 сум, 5 хилийн боомт хатуу хучилттай авто замаар нийслэлтэй холбогдоод байна. Үлдэж буй 2 төсөл, арга хэмжээний Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км, Баянхонгор-Алтай чиглэлийн 96.7 км авто замыг барилгын ажлыг 2020 онд дуусгаж ашиглалтад оруулснаар баруун бүсийн Завхан, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий аймгууд нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар бүрэн холбогдоно.</p>

		<p>1.5. Улаанбаатар хотод эргэн төлөгдөх нөхцөлтэй баригдаж байгаа авто зам, гүүрийн төсөвт өртгийг тогтоож байгаа одоогийн зарчим, арга хэлбэрийг боловсронгуй болгож, улмаар хувийн хөрөнгө оруулалтыг татах замаар зарим чиглэлийн зам, гүүрийг барьж төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх арга хэмжээ авах, шинээр баригдах авто замын ажлыг ус зайлуулах ил болон далд байгууламжтай нь хамтруулан барьдаг технологид шилжих.</p>	<p>2010 оноос 2012 оныг дуустал Нийслэлд эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр 50 км авто зам барих ажлыг хийж гүйцэтгэсэн. Нийт 16 төсөл хэрэгжүүлсэнээс 22-н товчоо чиглэлийн авто замаас бусад нь цагтаа ашиглалтад орсон.</p> <p>Эргэн төлөгдөх нөхцлөөр баригдсан авто зам, замын байгууламжийн төсөвт өртгийг холбогдох зураг төслийн хяналтын төсвийн дагуу тооцож, хэрэгжүүлсэн. Өөрөөр хэлбэл, үнийн өсөлтийг тооцоогүй байсан. Энэ нь 2 жил үргэлжлэх төслийн хувьд хүндрэлтэй, гүйцэтгэгчид алдагдалтай байдал ажиглагдсан. Цаашид эргэн төлөгдөх нөхцөлтэй зам барихад үнийн өсөлтийг холбогдох журмын дагуу тооцох хэрэгтэй.</p> <p>УБ хотод сүүлийн авто зам, замын байгууламжийн инженерийн нарийвчилсан зургаар барьсан бүх ажлуудад гадаргуун ус зайлуулах шугам баригдсан.</p>
		<p>1.6. Монгол Улс Азийн авто замын сүлжээнд нэгдсэн гол чиглэл болох Улаанбаатар-Замын үүд чиглэлийн хатуу хучилттай замын баригдаагүй үлдсэн хэсэгт дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, ажлыг эрчимжүүлэх замаар 2013 онд багтаан барьж ашиглалтад оруулах.</p>	<p>Азийн авто замын сүлжээний АН-3 чиглэл буюу Замын Үүд-Сайншанд-Чойр-Улаанбаатар чиглэлийн 432.1 км хатуу хучилттай замыг Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламж, хөнгөлттэй зээл, АНУ-ын Мянганы сорилтын сангийн буцалтгүй тусламж, БНХАУ-ын Засгийн газрын хөрөнгөөр Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл-ийн 4-н багцад хуваан хэрэгжүүлж, байнгын ашиглалтад оруулсан.</p> <p>Багц А -176,43 км Чойроос 35-р зөрлөг хүртэл Багц В -131.3 км 35-р зөрлөгөөс 18-ийн худаг хүртэл Багц NP1- 62,2 км 18-ийн худагаас 62 дахь км хүртэл Багц NP2 - 61,8 км 62 дахь км-ээс Замын Үүд хүртэл</p>
		<p>1.7. Монгол орны нөхцөлд тохирсон авто зам, замын байгууламжийн шинэ хийц, бүтээц, технологи нэвтрүүлэх, мэргэжлийн боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх, ажлын чанар, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэхэд чиглэгдсэн судалгаа, шинжилгээ, сургалтын ажил эрхлэх чиг үүрэг бүхий эрдэм шинжилгээ, зураг төслийн институтыг төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор Авто замын газрын дэргэд байгуулах.</p>	<p>Засгийн газрын бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Засгийн газрын 2012 оны 6 дугаар тогтоолоор Авто замын газар татан буугдсан.</p> <p>Авто замын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь Монгол Улсын Их Хурлаар 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдөр батлагдсан ба мөн оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Хуулийн 11 дүгээр зүйлд заасан Авто замын судалгаа, шинжилгээ хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллагын чиг үүргийг Засгийн газрын бүтэц зохион байгуулалтын хүрээнд “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-т хариуцуулах, тус үйлдвэрийн газрын дүрмийг шинэчлэх, бүтэц, орон тоог өөрчлөн тогтоох асуудлыг Засгийн газарт 2019 оны 10 дугаар сарын 02-ны өдөр танилцуулж, дэмжүүлсэн ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүний дүнд салбарын төрийн байгууллагын эрх, үүргийн хэрэгжилтийг хангах байгууллага, институцын тогтолцоо тодорхой болж байна.</p> <p>Авто замын тухай хуульд заасан авто замын норм, нормативын санг байгуулж, сангийн үйл ажиллагааг зохион байгуулах эрх, үүргийг “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-т олгосон ба тус сангийн үйл ажиллагаа үр дүнгээ өгч байна. Тус сангийн хөрөнгөөр салбарын судалгаа, шинжилгээний ажлыг бодит хэрэгцээ, шаардлагад нийцүүлж боловсруулсан жил бүрийн батлагдсан төлөвлөгөөгөөр зохион байгуулж байгаа ба үүний дүнд салбарын эрдэм, шинжилгээ, судалгааны үндсэн дээр хөгжих, үйл ажиллагааны чанар стандарт сайжирах үндсэн нөхцөл бүрдэж байна.</p>
4.	Валютын ханш, газрын тосны бүтээгдэхүүний	1.1. Өрсөлдөөний тухай хуулийн дор дурдсан заалтуудыг нэн яаралтай хэрэгжүүлж, холбогдох мэдээллийг	а/ ШӨХТГ-ын орон тооны 2, орон тооны бус 6 гишүүнийг Засгийн газрын 2012 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 73 дугаар тогтоолоор томилсон. б/, г/ Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын даргын 2017.1.03-ны өдрийн 1/03 тоот

<p>үнийн тогтвортой байдлыг хангах талаар цаашид авах арга хэмжээний тухай 2012.02.08 №10</p>	<p>ирүүлэх: а/ Хуулийн “17.1. Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар нь хамтын удирлагын зарчмаар ажиллах бөгөөд дарга, найман гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба гишүүдийн хоёр нь орон тооны, зургаа нь орон тооны бус байна”, “17.2. Шударга өрсөлдөөн, хэргэлэгчийн төлөө газрын дарга, орон тооны хоёр болон орон тооны бус гурван гишүүнийг Ерөнхий сайд, орон тооны бус гурван гишүүнийг Монголын худалдаа аж үйлдвэрийн танхим, Монголын үйлдвэрчний эвлэл, хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага тус тус нэг хүнийг нэр дэвшүүлж Засгийн газар томилж, чөлөөлнө”; б/ Хуулийн “13.3. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас учирсан хохирлыг нөхөх, эдийн засгийн хямралыг даван туулах, стратегийн гол бараа бүтээгдэхүүн тухайлбал, Улсын нөөцийн тухай хуульд заасны дагуу УИХ-аас тогтоосон бараа /Стратегийн нөөцийн бараа, материалын нэр, төрөл батлах тухай УИХ-ын 2008 оны 30 дугаар тогтоолд заасан/ эрэлт, нийлүүлэлтийн зохистой байдлыг бүрдүүлэн хэрэглэгчийн амьжиргааны түвшний тогтвортой байдлыг хангахад зориулж Засгийн газар, түүний эрх олгосон байгууллагаас зохицуулалт хийх, зээл олгох, тусламж үзүүлэхийг өрсөлдөөнийг хязгаарласанд тооцохгүй”; в/ Хуулийн “14.2. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дүрмийг Засгийн газар батална”, “7.2. Давамгайл байдалтай аж ахуй эрхлэгчийн бараа, бүтээгдэхүүний хэт өндөр үнийг тогтоохтой холбогдсон журмыг олон улсын тэргүүн туршлагыг үндэслэн Засгийн газар батална”;</p>	<p>удирдамжийн дагуу автобензин, дизель түлшний худалдаа эрхлэгч зарим аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. “Петростар” ХХК, “Шунхлай трейдинг” ХХК, “Магнай трейд” ХХК 2017.02.04-ний өдрөөс автобензин, дизель түлшний жижиглэнгийн үнийг 1 литр тутамд 100 хүртэл төгрөгөөр нэмэгдүүлж, бусад аж ахуй эрхлэгчид 2017.02.06-ны өдрөөс эхлэн дээрх аж ахуй эрхлэгчдийг дагах байдлаар үнийг ижил хэмжээнд нэмэгдүүлсэн байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газраас эдийн засгийн хямралыг даван туулах, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор автобензин, дизель түлшний жижиглэнгийн үнийг тогтвортой байлгахын тулд хийсэн зохицуулалт, “Үнийн зөвлөл”-ийн 2017.01.13-ны өдрийн III хуралдаанаас гарсан зөвлөмжийг тус тус зөрчсөн тул Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д “Засгийн газраас нийтийн ашиг сонирхол, үндэсний аюулгүй байдлыг хангах, үр ашигтай өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэх үүднээс зарим төрлийн аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлд тодорхой хугацаагаар хязгаарлалт хийж болно.” гэж заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас эрх олгосон байгууллага, албан тушаалтны зохицуулалт, шийдвэрийг хэрэгжүүлээгүй аж ахуй эрхлэгчдийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх дүгнэлт, саналыг Монгол Улсын Шадар сайд болон Уул, уурхай хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлсэн. в/ ШӨХТГ-ын дүрмийг Засгийн газрын 2012 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн 66 дугаар тогтоолоор баталсан. Давамгайл байдалтай аж ахуй эрхлэгчийн бараа, бүтээгдэхүүний хэт өндөр үнийг тогтоохтой холбогдсон журмыг боловсруулсан боловч Олон улсад энэ журам үүднээс батлагдаагүй.</p>
---	--	---

		<p>г/ Хуулийн 13.3 дахь заалт болон Стратегийн нөөцийн бараа, материалын нэр, төрөл батлах тухай УИХ-ын 2008 оны 30 дугаар тогтоолын хэрэгжилт.</p>	
		<p>1.2. ОХУ-тай газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлтийг харьцангуй тогтвортой байлгах, улмаар нефтьгүй орнуудын туршлагыг судалж, сайн нөхцөлийг тохирох зорилгыг хэрэгжүүлэхийн тулд энэ асуудалтай холбогдсон Засгийн газар хоорондын өнөөгийн гэрээ, хэлэлцээр нь Дэлхийн худалдааны байгууллага, Олон улсын эдийн засаг, хөгжлийн хамтын ажиллагааны нийгэмлэг /OECD/, нефтийн экспортын худалдаа эрхэлдэг орнуудын нийгэмлэг /OPEC/ зэрэг холбогдох олон улсын байгууллагуудын дүрэм, журам, гэрээ, хэлэлцээрийн нөхцөлүүдтэй хэрхэн нийцэж байгаа талаар санал, дүгнэлт гаргаж, Монгол Улсын төрөөс энэ чиглэлээр баримтлах бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж танилцуулах;</p>	<p>ОХУ-ын “Роснефть” компанитай 2014 оны 05 дугаар сард Хамтран ажиллах урт хугацааны Бүтээгдэхүүн нийлүүлэх үндсэн гэрээг байгуулсан. Уг гэрээг байгуулахдаа Дэлхийн худалдааны байгууллага, Олон улсын эдийн засаг, хөгжлийн хамтын ажиллагааны нийгэмлэг /OECD/, Газрын тосны экспортлогч орнуудын нийгэмлэг /OPEC/ зэрэг холбогдох олон улсын байгууллагуудын дүрэм журам, гэрээ хэлцлүүдийн нөхцөлтэй уялдуулан олон улсын биржийн үнэнд суурилсан томъёоллоор сар бүр шатахууны импортын үнийг тооцож байхаар тусгасан.</p> <p>Мөн ОХУ-ын Санктпетербург хотноо олон улсын эдийн засгийн 18-р чуулганы үеэр 2018 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Бүтээгдэхүүн нийлүүлэх үндсэн гэрээний хугацааг 2023 он хүртэл 5 жилийн хугацаагаар сунгасан болно. Мөн Монгол Улсын 9 компанитай нэмж гэрээг сунган байгуулсан.</p> <p>Мөн Төрөөс газрын тосны салбарт 2027 он хүртэл баримтлах бодлогын баримт бичгийн боловсруулан 2018 оны 06 дугаар сарын 06-ны өдөр Засгийн газрын хуралдаанаар батлуулсан. Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг УУХҮС-ын тушаалаар батлуулан хэрэгжүүлж байна.</p>
		<p>1.3. ОХУ-тай газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ, хэлэлцээр хийхдээ санхүүгийн арилжааны хэрэгсэл болох харилцан ашигтай байх, үнийн хэлбэлзлийн эрсдлийг тооцох /derivative/, гол нөхцөлүүд нь 3 болон түүнээс дээш сарын хугацаанд мөрдөх боломж байх харилцааг зохицуулдаг арилжааны хэрэгслийн төрөл /futures trade, option, swap/-ийг зайлшгүй ашиглах талаар холбогдох байгууллагуудтай тохирч чиглэл өгөх;</p>	<p>Уул уурхайн яам, Монгол банкттай хамтран 2012 оны IV улирлаас 2015 оны 03 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл “Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах SIFS” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Энэхүү хөтөлбөр нь шатахууны хил үнэнд валютын ханшийн өөрчлөлтөөс нөлөөлөх нөлөөллийг бууруулах, шатахууны жижиглэнгийн үнийг тогтворжуулах зорилготой хэрэгжүүлсэн. Хөтөлбөрийн 3 жилийн хугацаанд хэрэгжиж нийт 14 аж ахуйн нэгжид 222,8 тэрбум төгрөгийн хөнгөлттэй зээл олгон 2015 оны 02 дугаар сарын 12-ны өдөр хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар дүгнэлтийг гарган холбогдох ЗГ, УИХ-д тайланг хүргүүлсэн.</p> <p>Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 08-ний өдрийн 2 дугаар тэмдэглэлээр Ашигт малтмал, газрын тосны газарт шатахууны үнийг тогтворжуулах зорилгоор холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасан.</p> <p>Засгийн газрын 2020 оны 114 дүгээр тогтоолоор санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан бүх төрлийн шатахууны жижиглэнгийн үнийг тогтворжуулах арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд болон Ашигт малтмал, газрын тосны газарт үүрэг болгосон. Дээрх тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг ЗГ-ын 2020 оны 14 дүгээр тогтоолоор байгуулагдсан “Эрчис ойл” төрийн өмчит компаниар дамжуулан хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд 2020 оны 06 дугаар сараас 12 дугаар сар хүртэл АИ-92 автобензиний жижиглэнгийн үнийг тогтворжуулах хамтын ажиллагааг газрын тосны импорт, бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 22 аж ахуйн нэгжтэй байгуулан үнийг 1350 төгрөгөөр тогтворжуулахаар гэрээ байгуулан ажиллаж байна.</p>

		<p>1.4. Гадаад оронтой газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ, хэлэлцээрт Засгийн газар шууд оролцох, тэдгээрийг худалдан авах хэлэлцээр, хилийн болон бөөний, жижиглэн худалдааны үнийн бүтэц, ложистикт холбогдох хуульд заасны дагуу Сангийн яам, Гаалийн Ерөнхий газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Татварын Ерөнхий газартай хамтран ил тод байдлыг бүрдүүлж, хяналт тавих тогтолцоо, механизмыг оновчтой тогтоож, эрх зүйн орчинг боловсронгуй болгох;</p>	<p>Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын комиссын хуралдаанд Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ, хэлэлцээр, тоо хэмжээ, тээвэр ложистикийн асуудлыг жил бүр тусгуулж, хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 15 дугаар тогтоолоор байгуулагдсан “Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, үнийг тогтворжуулах ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтарсан Зөвлөл” нь газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тухайн үеийн байдал, гадаад, дотоод зах зээлийн нөхцөл байдал, дэлхийн газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл, нөөц, нийлүүлэлт, импортын үнийн хөдөлгөөн, тулгамдаж буй асуудлууд зэрэгтэй гишүүд тодорхой танилцаж, нөхцөл байдлыг хамтран хэлэлцэн, санал бодлоо солилцох, гарах гарцыг хайх, улмаар нэгдсэн шийдвэрт хүрч Хамтарсан Зөвлөлийн “Зөвлөмж” гарган холбогдох байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллаж байна. Шатахууны Онцгой албан татварыг хэмжээг газрын тосны бүтээгдэхүүний төрөл, чанар, стандарт, импортлож буй боомттой уялдуулан тогтоох, Агаарын чанар сайжруулах бүсэд Евро-5 стандартын шаардлагад нийцээгүй шатахуун борлуулахыг хориглох эрх зүйн орчин бүрдүүлэх, чанарын хяналтын нэгдсэн тогтолцоо бий болгох асуудлуудыг ОББҮХ-ны 2018 оны 10 дугаар сарын 13-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2018 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 18/03-1 дугаар тогтоолын 15 дахь заалтаар Шатахууны хангамж, чанарын хяналтын тогтолцоо бүрдүүлэх, ажлын уялдаа холбоог сайжруулах, мэдээлэл, хяналтын нэгдсэн систем бий болгох асуудлыг судалж, санал дүгнэлт гаргах хамтарсан ажлын хэсэг байгуулж ажиллахыг Гаалийн ерөнхий газар /Б.Асралт/, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар /Н.Цагаанхүү/, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар /Б.Лхагва/, Ашигт малтмал, газрын тосны газар /Х.Хэрлэн/-т тус тус даалгасан. Тус тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, ажлын явц, үр дүнг тухай бүр тайлагнан ажиллах тухай чиглэл хүргүүлэх 2018.12.17-ны 02/3389 тоот албан бичгийг АМГТГ-т явуулсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 06 сарын 13-ны өдрийн 03/1793 тоот тушаалын дагуу нэгдсэн мэдээллийн сан, хяналтын механизм бүхий программыг хийх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</p>
		<p>1.5. Улсын нөөцийн тухай хууль, Өрсөлдөөний тухай хуулийн 13.3, Стратегийн нөөцийн бараа, материалын нэр, төрөл батлах тухай УИХ-ын 2008 оны 30 дугаар тогтоол, бусад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу газрын тосны бүтээгдэхүүний нөөцийг зардал багатай, оновчтой хувилбараар бүрдүүлэх;</p>	<p>2014 онд шинэчлэн батлагдсан Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд улсын болон компанийн нөөц бүрдүүлэхтэй холбоотой заалтууд тусгагдсан ба Засгийн газрын 2012 оны 126 дугаар тогтоолоор “Газрын тосны бүтээгдэхүүн импортоор оруулж бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлж байгаа компанийн нөөц бүрдүүлэх журам” баталсан. Журмын дагуу улсын хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүний хомсдол үүсч, үнийн хөөрөгдөл гарахаас урьдчилан сэргийлэх, эдийн засгийг тогтвортой байдлыг хангах нөхцөл бүрдүүлэх зорилгоор газрын тосны бүтээгдэхүүн импортоор оруулж бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлж байгаа компанийн нөөцийг бүрдүүлэх бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, байршлыг тодорхой болгох, түүнийг хадгалах, сэлгээ хийх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулж, харилцан үүрэг хүлээх зорилгоор жил бүр Засгийн газрын тогтоолоор компанийн нөөц бүрдүүлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжийн нэрсийн жагсаалт, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг шинэчлэн баталж байна. Засгийн газрын 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 409 дүгээр тогтоолоор 2020 онд газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн</p>

		<p>1.6. Дотооддоо олборлосон түүхий нефтийг боловсруулах болон нүүрснээс шингэн хий, нефть гаргах үйлдвэр байгуулах ажлыг хурдавчлах. Үүнд:</p> <p>а/ МУ-д аливаа ашигт малтмалын олборлолт явуулсан аж ахуй эрхлэгч нь дотоодын боловсруулах үйлдвэрүүдэд зах зээлийн үнээр тэргүүн ээлжинд түүхий эдээ нийлүүлэх үүрэг хүлээдэг болохтой холбогдуулж Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах;</p> <p>б/ “Нүүрс-устөрөгчийн тухай” хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэх;</p> <p>в/ Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн мэдүүлэх;</p> <p>г/ Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнд өөрчлөлт оруулах.</p>	<p>нэгжийн нэрсийн жагсаалт, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг батлаад байна.</p> <p>Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2014 онд УИХ-аар баталсан ба тус хуулийн 7.1.6. -д Монгол Улсад газрын тос боловсруулах үйлдвэр барьсан тохиолдолд гэрээлэгчид ногдох газрын тос болон өртөгт газрын тосыг тэргүүн ээлжинд, зах зээлийн үнээр худалдаж авах давуу эрхийг Засгийн газар эдлэхээр тусгасан. Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдан хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Засгийн газрын 2015 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 114 дүгээр тогтоолоор Бүтээгдэхүүн хуваах гэрээний загварыг баталсан ба хууль батлагдахаас өмнө байгуулсан БХГ-нүүдийг тогтоолоор батлагдсан загварт нийцүүлэн шинэчлэх ажлыг зохион байгуулсан бөгөөд газрын тосны хайгуулын БХГ-нүүдийг шинэчлэн байгуулаад байна.</p>
		<p>1.7. Өрсөлдөөний тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжуудыг иргэд, олон нийт, аж ахуйн нэгжүүдэд таниулах сургалт, сурталчилгааны ажлыг өргөн зохион байгуулах;</p>	<p>Холбогдох хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр байгууллагын цахим хуудсаар нийт 12 удаагийн онлайн сургалтыг зохион байгуулсан. Тус газраас Засгийн газрын 2020 оны 78 дугаар тогтоолоор өгөгдсөн “Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлт, борлуулалтын байдал, нөөц, үлдэгдлийн хөдөлгөөнд өдөр тутамд хяналт тавьж, нийлүүлэлтийн болон үнийн түвшинг тогтвортой байлгах, үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсгэх, хэт нөөцлөх, дамлан худалдаалахаас сэргийлэх арга хэмжээ авч ажиллах” үүргийн дагуу Нийслэлийн 9 дүүрэг, Төв аймгийн зах, худалдааны төвүүдэд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр хяналт шалгалтуудыг зохион байгуулж хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.</p> <p>Зар сурталчилгааны тухай хуулийн хүрээнд Орхон аймгийн ЗДТГ, Булган аймгийн ЗДТГ, Эрдэнэт ТӨҮГ-ын 115 гаруй хүнд сургалт зохион байгуулсан. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа 38 телевиз, фм, радиод зөвлөмж хүргүүлсэн.</p> <p>Монгол Улсын Их хурлын сонгуулийн хуулийн талаарх онлайн сургалтыг орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагуудад зохион байгуулсан. Сонгуулийн хуулийн хэрэгжилтийг хангах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэвлэл мэдээллийн 160 байгууллага, улсын төрийн 35 намд зөвлөмж хүргүүлсэн.</p> <p>Өрсөлдөөний хуулийн чиглэлээр хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлт, борлуулалтын байдал, нөөцөд хяналт тавьж, нийлүүлэлтийн болон үнийн түвшинг тогтвортой байлгах, үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсгэх, хэт нөөцлөх, дамлан худалдаалахаас сэргийлэх зорилгоор хяналт шалгалтын ажлуудыг аж ахуйн нэгжүүдийг зөвлөгөө зөвлөмжөөр ханган ажиллаж байна.</p> <p>Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн чиглэлээр иргэд хэрэглэгчдэд хуулийг сурталчлах онлайн сургалтыг зохион байгуулсан. Мөн Олон улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдрийг “Тогтвортой хэрэглээ-Хариуцлагатай хэрэглэгч” сэдвийн хүрээнд улс</p>

		<p>2.1. Төв банк /Монголбанкны/-ны тухай болон холбогдох бусад хуульд дараах өөрчлөлтийг оруулах:</p> <p>а/МУ валютын ханшийн чөлөөтэй хөрвөдөг тогтолцоотой хэдий ч бодит байдал дээр энэхүү чөлөөт байдал нь Монголын эдийн засгийн валютын нийт эрэлт хэрэгцээг бүрэн дүүрэн илэрхийлж байгаагүй бөгөөд цөөхөн хэдэн оролцогчид арилжааны банкуулын хязгаарлагдмал эрэлтээр тодорхойлогдож байгааг харгалзан валютын ханшийн “чөлөөтэй хөвөх дэглэм”-ийг өөрчилж “зохицуулалттай хөвөх ханшийн дэглэм”-д шилжих хууль эрх зүйн орчин бүрдүүлэх эсэх талаар судалгаа хийж, санал боловсруулж, танилцуулах;</p> <p>б/ “Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл”-ийн эрх, үүргийг хуульчилж, энэ зөвлөлөөс олон нийт болон УИХ-ын ЭЗБХ-нд тогтмол хугацаанд мэдээлэл хийлгэдэг болгох;</p> <p>в/ Нефть импортлогч компаниуд болон бусад томоохон импортлогчдыг тогтвортой санхүүжилтээр хангахын тулд арилжааны банктай санхүүгийн арилжааны хэрэгсэл /derivative/, арилжааны хэрэгслийн төрөл /futures trade, option, swap/-ийг ашигласан хэлэлцээр хийж ажиллахад Монголбанк, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс дэмжлэг үзүүлэх;</p> <p>г/ Монголбанкны гадаад валютын нөөцийн удирдлага, түүний үйл ажиллагааны үр дүнг ил тод болгохыг судлан үзэж, шаардлагатай бол холбогдох хуульд өөрчлөлт оруулах;</p> <p>д/ Валютын ханшийн эрсдлээс хамгаалах үндэсний хэмжээний тогтолцоо, механизмыг бүрдүүлэх, энэ зорилтын хүрээнд арилжааны банкууд, банк бус</p>	<p>орон даяар тэмдэглэн өнгөрүүлээ. Зах, худалдааны төвүүдэд хэрэглэгчээ дээдэлсэн үйл ажиллагаа явуулах талаар зөвлөмж хүргүүлсэн.</p> <p>Б/ УИХ-аас 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр баталсан “Төв банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулиар Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн чиг үүрэг, Зөвлөлийн бүрэлдэхүүн, Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлуудыг хуульчилж өгсөн. Үүнтэй холбоотойгоор Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх зарилын 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А-342/659/310/74 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ажиллах дүрэм” -ийг шинэчлэн баталсан. Энхүү шинэчлэн батлагдсан дүрэмд Зөвлөлийн зорилго, үйл ажиллагааны зарчим, эрх үүрэг, Зөвлөлийн хуралдааны дэг, Зөвлөлийн Ажлын албаны бүтэц, зохион байгуулалт зэрэг асуудлуудыг тусгасан байна.</p> <p>УИХ-ын чуулганы 2018 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаар “Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт өөрчлөлтийн төслийг баталсан бөгөөд тус хуульд орсон гол өөрчлөлт нь “Мөнгөний бодлогын зөвлөл” болон банкны хяналт шалгалтын шийдвэрийг гаргадаг “Банкны хяналт шалгалтын хороо” байгуулахаар тусгаж, төсвийн шинж чанартай санхүүжилт-хөтөлбөрийг Монголбанкнаас санхүүжүүлж, мөнгөний бодлогын зорилт үр нөлөөг алдагдуулдаг байдлыг арилгах зорилгоор Засгийн газарт зээл олгох, Засгийн газрын үнэт цаасыг худалдан авах Монголбанкны үйл ажиллагааг тодорхой зааж, хязгаарлалтыг тусгасан. Тогтоолын а, б, в, е дэх заалтыг Монголбанк хариуцан хэрэгжүүлнэ г,д/ Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар валютын удирдлагыг сайжруулах, валют арилжааны биржийн үйл ажиллагааг явуулах зохицуулалтыг тусган УИХ-ийн гишүүн М.Оюунчимэг гишүүн өргөн барьж хэлэлцэгдэхээр хүлээгдэж байна.</p>
--	--	--	--

		санхүүгийн байгууллагууд, томоохон экспортлогчид, импортлогчдыг шууд оролцуулсан “Валютын бирж” байгуулах шийдвэрийн төслийг УИХ-д танилцуулахыг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлтэй хамтран зохион байгуулах; е/ МУ-ын эдийн засаг дахь долларжилтыг зохистой түвшинд барих, хяналтыг боловсронгуй болгох арга хэмжээ авах.	
5.	“Түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2015.02.05 №02	1.2/ Улаанбаатар хотын 5-р цахилгаан станцыг барих ажлыг шуурхайлах, бага өртөг зардлаар цахилгаан үйлдвэрлэх зорилгоор Багануур болон бусад уурхайн дэргэд эрчим хүчний шинэ эх үүсгэвэр барьж байгуулах, цаашид эрчим хүч экспортлох, түүнд шаардагдах шугам сүлжээг бий болгох;	5-р цахилгаан станц: Шалгаруулалт явагдаж улмаар концессын гэрээгээр тус төслийг хэрэгжүүлэхээр шалгарсан “Фифт Комбайнд Хийт Энд Пауэр Плант” ХХК-тай 2014.06.20-ны өдөр гэрээ байгуулсан. Ажлын хэсэг концесс эзэмшигчтэй “Эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ”-ний хэлэлцээрийг хийж 2015 оны 7 дугаар сард “ДҮТ” ХХК, “ЦДҮС” ТӨХК болон концесс эзэмшигч нь гэрээг байгуулсан. Төслийн нийт хөрөнгө оруулалт 1,5 тэрбум ам.доллар байх бөгөөд концессын гэрээний хугацаа 25 жил, барилгын ажлыг гүйцэтгэх хугацаа 4 жил. Эрчим хүчний эх үүсвэр барих тусгай зөвшөөрөл авах өргөдлийг 2016 оны 3 дугаар сард Эрчим хүчний зохицуулах хороонд өгсөн боловч Эрчим хүчний тухай хуулийн 21.2.5-д заасан “Эрчим хүчний хангамж, хэрэглээний тэнцэл” хангагдаагүй, зохицуулалтын бодлого чиглэлд нийцэхгүй байгаа тул тусгай зөвшөөрөл олгогдоогүй. Төслийн ажлын явцын талаар Сайдын зөвлөлийн 2018.01.04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, цаашид хэрхэн үргэлжлүүлэх талаар тайлбар, танилцуулга боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэр гаргуулахаар шийдвэрлэсэн. Төслийн гүйцэтгэгч компани төсөл хэрэгжүүлэгч консорциумаас гарсан тул төсөл хэрэгжих боломжгүй болоод байна.Багануурын станц: Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан Концессын зүйлийн жагсаалтад тусгагдсан Багануурын станцыг барих сонгон шалгаруулалт явуулж, БНХАУ-ын Цөмийн эрчим хүчний корпораци шаардлага хангасан төслийн санал ирүүлсэн тул Концессын гэрээг 2015.04.01-нд Хөрөнгө оруулалтын газартай байгуулсан. Цахилгаан эрчим хүч худалдах худалдан авах гэрээг 2015.08.28-нд байгуулсан. Төслийн талбайн судалгааны ажлыг 2015.12.23-нд эхлүүлсэн. Концесс эзэмшигч нь газар шорооны ажлыг 2016 оны III улиралд эхлүүлсэн. Санхүүжилтээ шийдвэрлэсэн талаар мэдэгдэл ирүүлсэн. 2017 онд Багануурын цахилгаан станцын Концесс эзэмшигч “Багануур Пауэр” ХХК-ийн төлөөлөлтэй уулзалт хийж Монголын эрчим хүчний системд ажиллах боломжийн талаар судалж ТЭЗҮ-д нэмэлт оруулж танилцуулах талаар санал илэрхийлсэн. Концессын болон дагалдах гэрээнд өөрчлөлт оруулахаар тохиролцон ЗГ-т асуудал оруулсан. ЗГ-ын 2017.05.30-ны өдрийн 158 дугаар тогтоол гарсан. Энэ тогтоолоор “Багануурын цахилгаан станц төсөл”-ийн ТЭЗҮ-д өөрчлөлт орсонтой холбогдуулан уг төслийг барих-ашиглах-шилжүүлэх төрлөөр хэрэгжүүлэхээр ХОГ болон “Багануур Пауэр” ХХК-ийн хооронд 2015.04.01-ний өдөр байгуулсан концессын гэрээний хүрээнд байгуулагдсан “Нүүрс худалдах, худалдан авах гэрээ”, “Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ”-нд нэмэлт, өөрчлөлт оруулах арга хэмжээ авах үүрэг өгөгдсөний дагуу ажиллаж байна. “Багануур Пауэр” ХХК-тай концессын гэрээнд өөрчлөлт оруулах асуудлаар хэлцэл хийх ЭХЯ, ЭХЗХ, ДҮТ, ТХН-ийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг Эрчим хүчний сайдын 2018.11.20-

			<p>ны 163 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг 2018.11.23-ны өдөр “Багануур Пауэр” ХХК-ийн удирдлагуудтай хэлцлийг эхлүүлж, Монголын талаас төсөл эхэлсэн эхний 4 жилд зуны бага ачааллын үед 1х150 МВт, өвлийн их ачааллын үед 2х150 МВт, тав, зургаа дахь жилээс 440 МВт болгож ДҮТ-ийн зохицуулалттайгаар ажиллах саналыг тавьсан. Ажлын хэсэг “Багануур Пауэр” ХХК-ийн удирдлагуудтай хэлцлийг үргэлжлүүлж байна. Багануурын дулааны цахилгаан станцын нэгж хүчин чадлыг Монгол Улсын Эрчим хүчний нэгдсэн системийн горим, аюулгүй байдлыг хангахад хамгийн тохиромжтой байдлаар нэгж блокийн хүчин чадлыг 150-200 МВт болгон бууруулах чиглэлээр концесс эзэмшигч “Багануур пауэр” ХХК-тай ойрын хугацаанд хэлэлцээр хийх шинэ нөхцөл байдал үүссэн тул тус станцын талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар хүргүүлсэн материалыг үүгээр түр буцаан татсан. Эрчим хүчний яамнаас нэгж тоноглолын хүчин чадлыг эрчим хүчний системийн хэвийн ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх талаар Концесс эзэмшигч “Багануур пауэр” ХХК-нд мэдэгдсэний дагуу тус компаниас нэгж турбины хүчин чадлыг 200 МВт байхаар Техник, эдийн засгийн үндэслэлийг шинээр боловсруулж байна. Техник, эдийн засгийн өгөгдлүүд өөрчлөгдөж байгаатай холбогдуулан концессын гэрээнд нэмж тусгах шаардлагатай болсон тул Багануурын станцын концесс эзэмшигч компанитай концессын гэрээнд өөрчлөлт оруулах хэлцэл хийхээр Үндэсний хөгжлийн газартай хамтран ажиллаж байна.</p> <p>Шинээр баригдах эх үүсвэрийг сүлжээнд холбох, мөн стратегийн ач холбогдол бүхий орд газруудыг цахилгаан эрчим хүчээр хангах, бүс нутгийг өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбох ажлын хүрээнд БНХАУ-ын урт хугацаатай хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Улаанбаатар-Мандалговийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын барилга угсралтын ажил 99%-ийн гүйцэтгэлтэй, бусад цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барьж байгуулахад шаардлагатай хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлэхээр ажиллаж байна.</p>
		<p>1.4/ Дулааны 3-р цахилгаан станцын 250мвт болон Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын өргөтгөл, Багануур, Шивээ-овоогийн нүүрсний уурхайн техникийн шинэчлэл, эрчим хүчний шинээр эхлэх буюу шинэчлэх шинэчлэх төсөл арга хэмжээнд хөгжлийн банкны гүүрэн санхүүжилтийн механизмыг хэрэгжүүлэх;</p>	<p>1.ОХУ-аас олгох зээлийн асуудал эцэслэн шийдвэрлэгдээгүй тул Дулааны III цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 250 МВт-аар нэмэгдүүлэх төслийн ажил эхлээгүй байна. Иймээс тус станцын дулааны ачааллыг Дулааны IV цахилгаан станцад шилжүүлэх ажлыг түр хойшлуулаад байна. Төслийн ажлыг эхлүүлэх, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх талаар ОХУ-ын холбогдох яамдтай хамтран ажиллаж байна. Мөн Эрчим хүчний сайдын 2018.01.19-ний өдрийн №10 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд Барилга угсралтын ажлыг эхлэх үед дулааны ачааллыг шилжүүлэх, боломжийг ДҮТ, УБДС, ДЦС-4, ДЦС-3, ДЦС-2-ын удирдлагуудын түвшинд хэлэлцэж тохиролцсон. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн хурлаар Улаанбаатарын дулааны гуравдугаар цахилгаан станцын хүчин чадлыг 250 МВт-аар нэмэгдүүлэх төслийн талаарх танилцуулгыг Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн танилцуулсан бөгөөд тус танилцуулгыг ҮАБЗ-д танилцуулж, төслийг хэрэгжүүлэх талаар зөвлөмж чиглэл авч ажиллахыг засгийн газрыг хуралдааны тэмдэглэлээр даалгасны дагуу ҮАБЗ-д танилцуулгыг 2020 оны 04 дүгээр сарын 07ны өдрийн а/1145 тоот албан бичгээр хүргүүлсэн бөгөөд хариу иргээгүй байна.</p> <p>2.“ЭДЦС” ТӨХК-ийн өргөтгөл, шинэчлэлийн ажлын хөрөнгийг Монгол Улсын Хөгжлийн банкны гүүрэн санхүүжилтаар санхүүжүүлэхээр шийдвэрлэсний дагуу Эрчим хүчний сайдын</p>

			<p>2015 оны 85, 115 дугаар тушаалаар үнэлгээний хороо байгуулагдан түлхүүр гардуулах нөхцөлтэй, олон улсын нээлттэй тендерийг 2015.07.09-ний өдөр зарлаж, сонгон шалгаруулсан. Гэвч санхүүжилтийн механизм өөрчлөгдөн уг төслийг БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх шийдвэр гарсан тул өмнөх тендерийг хүчингүй болгож дахин тендер зарласан. Тендерийн үнэлгээг хийж БНХАУ-ын Hunan Industrial Equipment Installation компанийг шалгаруулж, 2017 оны 3 дугаар сард гэрээ байгуулсан. Сангийн яамнаас БНХАУ-ын талтай зээлийн тусгайлсан хэлэлцээрийг 2018 оны 04 дүгээр сард хийсэн. ЭХЯ, БНХАУ-ын “Хунан Индустриал Экуйпмент Инстолэйшн” ХХК-тай 2017.01.17-ны өдөр байгуулсан гэрээний дагуу БУА-ын гүйцэтгэгчид 30%-ийн урьдчилгаа төлбөр төлөх үүрэг хүлээснийг 2018.08.31-ний өдрийн а/3101 тоотой Сангийн сайдад хүргүүлсэн. Төслийн гүйцэтгэгч компанид Монголын талын ногдох урьдчилгаа төлбөрийг 2018 оны 10 дугаар сард хийсэн. Валютын ханшийн зөрүүгээс шалтгаалан Монгол талаас 19,0 мянган долларын дутагдал үүссэнийг ажлыг шуурхай эхлүүлэх зорилгоор ЭДС-аас төлбөрийг хийлгэж 2019 онд эргэн төлөхөөр зохицуулсан. Сангийн сайдын 2018.10.04-ний өдрийн 240 дүгээр тушаалаар Төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулсан. Батлагдсан орон тооны дагуу төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудыг сонгон шалгаруулах үнэлгээний хороог Төрийн нарийн бичгийн даргын 2019.04.16-ны өдрийн тушаалаар байгуулсан. Ингээд олон нийтэд нээлттэй сонгон шалгаруулалтыг 2019.04.24-ний өдрийн Өдрийн сонин №084(6627) дугаарт зарлаж, 05 сарын 08-ны өдрөөр материал хүлээн авах хугацааг тасалбар болгож үнэлгээ хийсэн. Барилга угсралтын ажил гүйцэтгэх инженер техникийн ажилчдын түр оршин суух орон сууцны барилга угсралтын ажлыг хийж бэлэн болсон. Станцын өргөтгөл, дэд станц, шугамын өргөтгөлийн зураг төслийн ажил хийгдэж байна. Үүнээс 4 барилга объектын зураг төсөл батлагдахад бэлэн болсон. Станцын турбингенератор, насос, трансформатор болон бусад дагалдах тоноглол үйлдвэрлэлийн захиалга хийгдэж үйлдвэрлэгдэж байна. Төслийн хүрээнд турбин цех А, В, С тэнхлэгийн газар шороо, суурийн ажил, турбины газар шороо, нил суурь, тулаас зэрэг нь 100%-тай, эргэлтийн насос станцын газар шорооны ажил, эргэлтийн усан насосын суурийн ажил 100%-тай, анкер гадна шугамын хэмжилт, гардеринг газар шороо, суурийн ажил 100%-тай, давсгүйжүүлэх усан насос баригдах хэсгийн одоо байгаа байгууламжийг буулгах ажил 100%-ийн гүцэтгэлтэй бөгөөд бусад ажлууд графикайн дагуу хийгдэж байна. Барилгын үндсэн карказ, дээврийн ажил хийгдэж дуусах шатандаа, нийт захиалсан тоноглолын 20% нь импортоор орж ирсэн бөгөөд батлагдсан төлөвлөгөөний дагуу ажил хийгдэж байна.</p> <p>3.Эрчим хүчний сайдын Зөвлөлийн 2018 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн. “Багануур”, “Шивээ-Овоо” ХК-иудын урт хугацаат өр төлбөр, техникийн шинэчлэл болон тулгамдаж буй бусад асуудлуудыг цогцоор нь авч үзэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Эрчим хүчний сайдын хамтарсан Засгийн газрын тогтоолын төслийг ажил хэргийн шугамаар боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулахыг даалгасан. Үүний дагуу зохих ажлыг хийсний үр дүнд, Засгийн газрын 2018 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 132 дугаар тогтоолоор холбогдох асуудлууд шийдвэрлэгдсэн.</p>
6.	Шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх	1.1/ УИХ-ын 2010 оны 39, 2012 оны 18 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах шуурхай арга хэмжээ авч, "Эрдэнэс-	“Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай” Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолын нэгдүгээр хэсэгт Тавантолгойн нүүрсний ордыг ашиглахтай холбогдуулан “Эрдэнэс-Тавантолгой” компанийн хувьцааны 50 хүртэлх хувийг Монгол

	зарим арга хэмжээний талаар 2015.04.08 №10	тавантолгой" хувьцаат компанийн хувьцааны эзэмшлийн бүртгэлийг баталгаажуулах ажлыг 2015 онд багтаан хэрэгжүүлэх;	Улсын иргэн, үндэсний аж ахуйн нэгжүүдэд эзэмшүүлэх, дотоод, гадаадын хөрөнгийн биржээр арилжаалах талаарх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу үе шаттайгаар хэрэгжүүлэх, хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр худалдаж шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгасны дагуу ТУЗ-ийн 2019 оны 28 дугаар тогтоолоор "Эрдэнэс-Тавантолгой Майнинг" ХХК охин компани үүсэн байгуулагдсан. Улмаар ЗГ-ын тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд ТУЗ-ийн 51 дүгээр тогтоолоор үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, шаардлагатай зөвлөх үйлчилгээг сонгох ажлыг шат дараатайгаар зохион байгуулан ажиллаж байна. Түүнчлэн Тавантолгойн ордын үнэ цэнийг өсгөхөд холбогдох дэд бүтцийн болон шаардлагатай бусад төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх арга замыг судлах арга хэмжээг эрчимжүүлэн ажиллаж байна. Татвар төлсөн үндэсний 486 аж ахуйн нэгж хувьцаа эзэмшиж байна.
		1.2/ "Эрдэнэс таван толгой" хувьцаат компанийн Хөгжлийн банкнаас авсан зээлийг хувьцаанд хөрвүүлэх асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авах;	Компанийн мөнгөн урсгал, дотоод нөөц бололцоог ашиглан 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Монгол Улсын Хөгжлийн банктэй байгуулсан 200 сая ам.долларын Зээлийн гэрээний зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдэлийг бүрэн төлж барагдуулсан.
7.	Чиглэл өгөх тухай 2016.11.29 №07	1.1/ Япон Улсын МОНП-1, МОНП-2 төслүүдийн хөнгөлөлттэй зээлийг боломжит ханшаар төгрөгт шилжүүлэн тооцож, уг зээлийг 2017-2023 он хүртлэх хугацаанд төлөх нөхцөлийг судалж танилцуулах;	Япон Улсыг МОНП-1, МОНП-2 төслүүдийн хөнгөлөлттэй зээлийн хүрээнд олгосон дамжуулан зээлийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор Улсын Их Хурлын 2019 оны 52 дугаар тогтоол 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөгдөхөөр гарсан. Энэ асуудлын хүрээнд дамжуулан зээлийн үлдэгдэл төлбөрийг хөрөнгө оруулалт болгох асуудлыг шийдвэрлэх зорилгоор Оросын Холбооны Улстай хамтран хэлэлцээр хийхээр ажиллаж байна.
8.	Чиглэл өгөх тухай 2017.06.07 №15	1.1/ Засгийн газрын бүтцэд үндэсний хэмжээний урт, дунд хугацааны хөгжлийн төлөвлөлтийг боловсруулах, эдийн засаг, нийгэм, соёл, шинжлэх ухааны салбарын бодлогыг уялдуудан зохицуулах, салбар хоорондын тэнцвэрийг хангах үүрэг бүхий хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагыг зохион байгуулах асуудлыг судалж, санал, боловсруулан УИХ-ын ЭЗБХ-нд танилцуулах.	Үндэсний хөгжлийн газар нь 5 газар, 3 хэлтэс, 55 хүний орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үндэсний хэмжээний урт, дунд хугацааны нэгдсэн бодлого төлөвлөлт, салбарын бодлого зохицуулалт, тэдгээрийн хоорондын уялдаа, хөрөнгө оруулалт, төр хувийн хувийн хэвшлийн түншлэлийн бодлого, хэрэгжүүлэлт, суурь судалгаа, ТЭЗҮ-ийн тооцоолол, шинжилгээ судалгааг гүйцэтгэж байна. Үйл ажиллагааны стратеги, хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хүрээнд орон тоо, бүтцийг шинэчлэх саналыг боловсруулж, 2017 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн 01/1113 тоот албан бичгээр Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газарт санал хүргүүлсэн. Үндэсний хөгжлийн газрын бүтэц, орон тоог өргөтгөн зохион байгуулснаар үндэсний хэмжээний урт, дунд хугацааны хөгжлийн төлөвлөлт болон салбар хоорондын уялдаа, тэнцвэрийг хөрөнгө оруулалтын асуудалтай уялдуулан, судалгаа шинжилгээнд тулгуурлан боловсруулж, хэрэгжүүлэх нөхцөл бүрдэх юм. Тиймээс, Үндсэн хуульд 2019 оны 11 дүгээр сард нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг шинэчлэн найруулах төсөлд дээрх саналыг боловсронгуй болгон тусгасан.
		1.2/ Тогтоолын 1.1 дэх заалттай холбогдуулан Үндэсний хөгжлийн газрын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, чадавхийг дээшлүүлэх, хөгжлийн бодлого,	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудлаар яамд, агентлагуудын хариуцах чиглэлийг тодорхой болгох, уялдаа холбоог оновчтой тогтоох талаар Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Үндэсний хөгжлийн газрын даргын 2017 оны А-134 дугаар тушаалаар байгуулсан. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг шинэчлэх ажлыг Хууль тогтоомжийн тухай

		<p>төлөвлөлтийн асуудлаар яамд, агентлагуудын хариуцах чиглэлийг тодорхой болгох, уялдаа холбоог оновчтой тогтоох талаар Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулж, танилцуулах.</p>	<p>хуулийн дагуу нэмэлт, өөрчлөлтийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах, хувилбар боловсруулах, үзэл баримтлалын төслийг боловсруулах шаардлагын дагуу боловсруулсан. Түүнчлэн, энэ хуульд өөрчлөлт оруулах болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хувилбаруудыг олон улсын шилдэг туршлагад үндэслэн сайжруулж, эцэслэн боловсруулахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий олон улсын (НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр) болон үндэсний зөвлөхийн хийсэн судалгааны үр дүнд үндэслэн хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хувилбаруудыг боловсруулсан. Зөвлөхүүдээс гаргасан судалгааны үр дүнг хянасны дараагаар олон талын оролцоог хангасан хэлэлцүүлгийг зохион байгуулж, санал, зөвлөмж авсан.</p> <p>Дээрх ажлын үр дүнг харгалзан хууль санаачлагчаас бэлтгэсэн хуулийн төсөл болон дагалдан гарах хуулийн төслүүдэд зарчмын болон найруулгын саналыг тайлбарын хамт боловсруулж хууль санаачлагчид хүргүүлсэн. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2020 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн Улсын Их хурлын чуулганаар “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль” нэртэйгээр батласан.</p>
		<p>1.3/ Стратегийн ач холбогдол, үр ашиг бүхий хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрийн судалгаа, тооцоолол, технологийн шийдлийг олон улсын стандартын түвшинд боловсруулж, үнэлэх чадвар бүхий дагнасан судалгааны нэгжийг бий болгох.</p>	<p>2018 оны Ерөнхий сайдын захирамжаар Үндэсний хөгжлийн газар өөрийн бүтэцдээ дагнасан судалгааны нэгж болох Судалгаа, шинжилгээний газрыг 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Мөн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд Үндэсний хөгжлийн хүрээлэн нэртэйгээр тусгагдаж, батлагдсан.</p>
		<p>1.5/ Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, МУ-ын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулахдаа хөрш орнуудтай хамтран хэрэгжүүлэх “Эдийн засгийн коридор” төсөл болон хөдөө аж ахуй аялал, жуулчлал, аж үйлдвэр, эрдэс баялаг, дэд бүтэц, эдийн засгийн өндөр ач холбогдолтой өрсөлдөх чадвар бүхий төслүүдийг сонгон, тусгах арга хэмжээ авах.</p>	<p>Бүсчилсэн хөгжлийн бодлогын төсөлд бүс нутгийн эдийн засгийн интеграцид дэд бүтцийн нэгдсэн сүлжээгээр бүрэн холбогдож, эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах суурь нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор авто болон төмөр замын дэд бүтцийн томоохон төслүүд, аялал жуулчлалын төслүүд, чөлөөт бүс, хилийн боомтын төслүүд, эрчим хүчний томоохон төслүүдийг тусган оруулсан.</p> <p>МУ-ын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулахдаа 2018 онд 113, 2019 оны тодотголоор 149 төслүүдийг хөрш орнуудтай хамтран хэрэгжүүлэх “Эдийн засгийн коридор” төсөл болон хөдөө аж ахуй аялал, жуулчлал, аж үйлдвэр, эрдэс баялаг, дэд бүтэц, эдийн засгийн өндөр ач холбогдолтойгоор тусгасан.</p>
		<p>1.6/ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нийгмийн салбарт оруулах хөрөнгө оруулалтыг дэмжих.</p>	<p>УИХ-ын 2009 оны 64 дүгээр тогтоолоор Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого, Концессын тухай хуулийг 2010 онд тус тус баталсан. Концессын тухай хуулийн дагуу Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтыг баталсан. Уг жагсаалтад нийт 247 төсөл байгаагаас эрчим хүчний 21, авто замын 34, боловсролын салбарын барилга байгууламжийн 123, дэд бүтцийн 32, эрүүл мэндийн 13, бусад 24 төсөл багтсан.</p> <p>Дээрх жагсаалтаас нийт 60 төслийн концессын гэрээг байгуулсан /Цуцлагдсан гэрээнүүд хамрагдаагүй/-аас 23 төсөл бүрэн хэрэгжиж дууссан, 6 концессын гэрээ цуцлагдсан ба одоогоор хэрэгжиж буй 31 төсөл байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • “Барих-Шилжүүлэх” төрлийн 14 төсөл • “Барих-Шилжүүлэх”-ээс бусад төрлийн 17 төсөл байна.

			<p>Бүрэн хэрэгжиж ашиглалтад орсон Сургууль цэцэрлэгийн-15 төсөл, Авто замын-6 төсөл, Эрчим хүчний -2 төсөл байна. Хан-Уул дүүрэгт баригдаж байгаа 300 ор бүхий төрөх эмнэлгийн барилга угсралтын ажил 90 гаруй хувьтай байгаа бөгөөд 2020 оны 2 дугаар улиралд бүрэн ашиглалтад оруулахаар ажиллаж байна.</p>
		<p>1.8/ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлийн өндөр чадавх бүхий нарийн мэргэшсэн мэргэжилтнийг төлөвлөлтийн үндсэн дээр бэлтгэх тогтолцоог бүрдүүлэх.</p>	<p>1. Хөгжлийн бодлогын баримт бичгүүд (ХБББ)-ийн хоорондын уялдаанд үнэлгээ хийх, бодлогын тэргүүлэх зорилтыг тодорхойлох аргачлал” болон “Бодлогын зорилтуудын зорилтот түвшинг тодорхойлох аргачлал“-ыг 2017 оны 12 дугаар сард НҮБХХ болон Стокгольмын байгаль орчны хүрээлэнгийн дэмжлэгтэйгээр боловсруулсан. Тус аргачлалыг турших хүрээнд 3 тулгуурт хөгжлийн бодлогын Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Тогтвортой хөгжлийн зорилгуудад нийцсэн байдалд болон Сангийн яамнаас ирүүлсэн Монгол Улсын нийгэм, эдийн засгийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг 3 тулгуурт хөгжлийн бодлоготой болон Тогтвортой хөгжлийн зорилгын зарим хэсэгтэй харьцуулан үнэлсэн. Мөн аргачлалыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Эрчим хүчний яамны бодлого төлөвлөлт хариуцсан ажилтнуудад танилцуулах ажлыг зохион байгуулав. Аргачлалыг байгууллагын нийт албан хаагчид /2018 оны 3 дугаар сарын 5-ны өдөр/ болон эрдэмтдийн дунд /2018 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр/ танилцуулах ажлыг зохион байгуулав.</p> <p>Аргачлалыг Ерөнхий сайдын ахалсан ТХЗ-ын үндэсний зөвлөлийн 2018 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн анхдугаар хуралдаанаар танилцуулсан. Хуралдааны шийдвэрийн дагуу 2018 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар аргачлалыг “Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 294 дүгээр тогтоолыг батлах замаар Засгийн газрын 249 дүгээр тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулсан.</p> <p>2. Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, арга зүйн зөвлөгөө өгөх хүрээнд төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллагын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хөгжлийн бодлого төлөвлөх, бодлогын уялдааг үнэлэх, тогтвортой хөгжлийн зорилгыг бодлогод уялдуулан тусгах арга зүй, мэдээллийн талаар 150 гаруй төрийн албан хаагчид, 70 гаруй иргэний нийгмийн, эрдэм шинжилгээний болон хувийн хэвшлийн байгууллагын төлөөллүүдэд сургалт зохион байгуулсан болно.</p>
9.	<p>Банкны зээлийн хүүг бууруулах зах зээлийн орчныг бүрдүүлэх талаар чиглэл өгөх тухай 2018.04.18 №07</p>	<p>1.1/ 1.Банкны зээлийн хүүг бууруулах зах зээлийн орчныг бүрдүүлэх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монголбанк /Н.Баяртсайхан/, Санхүүгийн зохицуулах хороо /С.Даваасүрэн/-нд чиглэл болгосугай:</p> <p>Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх дэлгэрэнгүй төлөвлөгөөг боловсруулж, биелэлтийг</p>	<p>Монголбанк, СЗХ, Сангийн яамны төлөөлөл бүхий хамтарсан ажлын хэсгийн зүгээс “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 2019-2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулан Монголбанкны Ерөнхийлөгч, СЗХ-ны дарга, Сангийн сайд, ХДК-ийн гүйцэтгэх захирлын 2019 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн дугаар А-107/290/88/14 хамтарсан тушаалаар батлуулж, холбогдох байгууллагууд хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Холбогдох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг Монголбанкнаас хагас жил тутам нэгтгэн Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүдэд танилцуулан ажиллаж байна. Хамгийн сүүлд 2019 оны 12 сард хөтөлбөрийн биелэлтийг нэгтгэн танилцуулсан бөгөөд арга хэмжээний төлөвлөгөөнд тухайлсан нэг байгууллага эсвэл холбогдох байгууллагууд хамтран хэрэгжүүлэх нийт 88 арга хэмжээ туссанаас 43 нь бүрэн биелсэн, 43 нь хэрэгжих</p>

		<p>хангах;</p> <p>1.2/ хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх цогц арга хэмжээний хүрээнд хөрөнгө оруулалтын банк, сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани зэрэг институцийн хөгжлийг дэмжих, хөрөнгийн захад банкны зээлээс бусад санхүүжилтийн хэлбэрийг бий болгох, тэтгэврийн сангийн шинэчлэл хийх;</p>	<p>шатандаа, 2 нь хэрэгжүүлж эхлээгүй төлөв байдалтай байв.</p> <p>УИХ-д өргөн мэдүүлж, хэлэлцэж байгаа Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төслийг (Одоогоор "Гадаадын банкны тухай хууль" гэж өөрчилсөн) 2019.11.12-ны өдөр Ажлын хэсэг хэлэлцэж өргөн мэдүүлсэн хуулийн үзэл баримтлалын хүрээнд гишүүдээс гаргасан саналыг тусган өөрчлөх чиглэл өгөгдсөн. УИХ-ын 2018 оны 48 дугаар тогтоолоор баталсан МУ-ын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд "3.2.2.2. Гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй байлгах бодлого баримтална. Гадаадын төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орон, өндөр хөгжилтэй бусад орноос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлого баримтална" гэж заасны дагуу гадаадын төрийн өмчит банкнаас Монгол Улсад банк үүсгэн байгуулах харилцааг энгийн банкны үйл ажиллагаанаас ялгаатай байдлаар зохицуулах агуулгаар хуулийн төслийн саналд дараах өөрчлөлтийг орууллаа.</p> <ul style="list-style-type: none"> - Хуулийн төслөөр гадаадын төрийн өмчийн оролцоотой банк, хуулийн этгээдээс байгуулсан Монгол Улсад банкны үйл ажиллагаа эрхлэх банкныг "гадаадын банк" гэх; - Гадаадын банк үйл ажиллагааг зөвхөн томоохон төсөл санхүүжүүлэх зорилгоор хязгаарлагдмал хүрээнд эрхэлж болохоор тусгасан. Хөрөнгийн зах зээл дээр эрхлэх үйл ажиллагааг "Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрөлтэйгээр санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх; андеррайтерын үйлчилгээ; кастодиан" чиглэлээр тусгасан. - Банкны тухай хуулийн 6.2.1, 6.2.4, 6.2.5-д заасан үйл ажиллагааг эрхэлж болно" - Гадаадын банк байгуулах тохиолдолд МУ-ын Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвшөөрөл шийдвэр авсан байх. <p>Одоогоор Улсын Их Хурал дахь ажлын хэсгээс хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийлгэхээр бэлтгэж байна.</p>
		<p>1.3/ инфляцийн түвшинг нэг оронтой тоонд барихад чиглэсэн нэгдсэн бодлого хэрэгжүүлэх;</p>	<p>УИХ-аар батлагдсан Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл (ТМБҮЧ)-д тусгасны дагуу 2017-2020 оны инфляцийн зорилтыг 8%, 2021 оноос цааш дунд хугацаанд 6%-д хадгалах зорилтыг биелүүлэхэд чиглэсэн мөнгөний бодлогыг Монголбанк хэрэгжүүлж байна. Инфляци сүүлийн 3 жилд төв банкны зорилтот түвшний орчимд тогтвортой хадгалагдав. Тухайлбал, ХҮИ-ээр илэрхийлсэн инфляци улсын хэмжээд 2017 онд 6.4%, 2018 онд 8.1%, 2019 онд 5.2%, 2020 оны 3 дугаар сарын байдлаар 6.4% байв. Цаашид үнийн тогтвортой байдлыг хадгалах, инфляцийн дарамтгүй тогтвортой эдийн засгийн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн мөнгөний бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.</p>
		<p>1.4/ банк болон зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс бусад этгээдийн богино хугацаанд хэт өндөр ашиг олох зорилготой, мөнгө угаалтын шинж агуулсан зээл, зээллэг, өрийн хүү тооцох харилцааг хязгаарлаж, шаардлагатай тохиолдолд хүү,</p>	<p>Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авч зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын үйлчилгээнээс гадна тусгай зөвшөөрөлгүйгээр барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхэлж буй ломбард, лизинг, хувь хүнээс богино хугацаатай, өндөр хүүгээр зээлдүүлэх үйл ажиллагааг хязгаарлаж, хэт өндөр хүүтэй зээлийг иргэнд санал болгон худалдан борлуулах буюу зээлдэгчийн санхүүгийн хүндрэлтэй нөхцлийг ашиглан санхүүгийн дарамтад оруулах зэргийг хориглох эрх зүйн зохицуулалт бүхий "Санхүүгийн салбар дахь хэрэглэгчийн</p>

		хүүлэлтийн дээд хязгаарыг тогтоож, хяналт тавих;	<p>эрхийг хамгаалах тухай" хуулийн төслийг боловсруулж, хууль санаачлах эрх бүхий этгээдэд хүргүүлэв.</p> <p>Хуулийн төсөлд хүүг жилээр тооцох, хүү тооцох аргачлал болон мөнгө хүүлэлтийн шинжийг зах зээлийн хүүнээс хэт өндөр, зээлдүүлэгчийн үйл ажиллагааны зардал, үндэслэлгүйгээр ашиг бий болгосон зэрэг шинжээр тодорхойлж тусгалаа. Хуулийн төслийг 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн бөгөөд анхны хэлэлцүүлгийн шатанд байна.</p>
		1.5/ Ипотекийн зээлийн хөтөлбөрийг тогтвортой, зохистой хэмжээнд хадгалж, зээлийн санхүүжилтийг нэмэгдүүлэх;	<p>Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөр 2013 оноос хэрэгжиж эхэлснээс хойш 2019 оны байдлаар нийт орон сууцны зээлийн үлдэгдэл 4.6 их наяд төгрөгт хүрч, зээлийн жигнэсэн дундаж хүү 6.1 нэгж хувиар буурч 10.5 хувьд хүрсэн.</p> <p>Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Монголбанк, Засгийн газар, банкуудтай хамтран нийт 4.9 их наяд төгрөгийн эх үүсвэрийг банкуудаар дамжуулан иргэдэд олгов. Үүнээс Монголбанк 4.4 их наяд төгрөг, Засгийн газар 341.4 тэрбум төгрөг, банкууд 118 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгожээ. Ингэснээр ипотекийн зээлийн үлдэгдэл 2019 оны эцсийн байдлаар ДНБ-ний 12.7%-ийг эзэлж байна.</p> <p>Монголбанк 2018 онд ипотекийн зээлийн хөтөлбөрийг ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ИЗББ)-ын үндсэн төлбөрийн орлогоор сар бүр 16 тэрбум төгрөг, нийт 191.36 тэрбум төгрөгийн санхүүжилтийг банкуудаар дамжуулан 2,771 иргэнд, Засгийн газраас Улсын төсөвт тусгасан 118.4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 1,920 иргэнд, нийт 310 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг 4,691 иргэнд олголоо.</p> <p>Монголбанк 2019 онд хөтөлбөрийн санхүүжилтийн бүтцийг шинэчилснээр банкуудын эх үүсвэрийг татан оролцуулж хөтөлбөрийн хүртээмжийг нэмэгдүүллээ. Ингэснээр Монголбанк 2019 онд 213.4 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг 3,009 иргэнд, Засгийн газраас 112 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг 1,820 иргэнд, банкууд 118 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг 1,647 иргэнд олгож, нийт 443.3 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийн 6,476 иргэнд олгов.</p>
		1.6/ Монгол Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулах;	<p>Монголбанк нь Олон улсын зэрэглэл тогтоогч байгууллагуудыг Монгол Улсын зээлжих зэрэглэл үнэлэхэд шаардлагатай мэдээ, мэдээллээр тухай бүр хангаж, зээлжих зэрэглэлийн үнэлгээг ахиулахад идэвхтэй оролцон ажиллаж байна. Тухайлбал, 2018-2019 онд Эс энд Пи, Мүүдис болон Фитч агентлагуудтай хэд хэдэн удаагийн уулзалт зохион байгуулж, Монгол Улсын макро эдийн засгийн байдал, зээлжих зэрэглэлд нөлөөлж болзошгүй хүчин зүйлсийн талаар хэлэлцэж, зээлжих зэрэглэл тогтооход шаардлагатай мэдээллийг тухай бүр өгч ажиллаа.</p> <p>Зээлжих зэрэглэл, түүний ач холбогдол, үр нөлөөг таниулсан мэдээллийг бодлого боловсруулагчдад хүргэх үүднээс 2018 оны 10 дугаар сард Монголбанкнаас “Улсын зээлжих зэрэглэл, түүний ач холбогдол, тооцох аргачлал” товхимлыг бэлтгэв. Тус хэвлэмэл товхимолыг Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их хурлын дарга, Ерөнхий сайд, УИХ-ын гишүүд, УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, Хууль зүйн байнгын хороо, Төсвийн байнгын хороо болон холбогдох яам, агентлагуудад хүргүүлэв.</p>

			<p>Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч агентлагуудын тоон болон чанарын үнэлгээг ахиулах ажлын хүрээнд холбогдох арга хэмжээг авч ажиллав:</p> <p>1. Олон улсын зээлжих зэрэглэлийн Мүүдис агентлагаас ээлжит үнэлгээний тайлантай холбоотойгоор Монголбанкнаас ОУВС-ийн шаардлагын дагуу банкныг дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагаа ямар шатанд явагдаж байгаа тухай болон холбогдох тоон мэдээллийг 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр хүргүүлсэн. Мүүдис агентлагаас 2020 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр гаргасан хэвлэлийн мэдээнд Монгол Улсын Засгийн газарт өгсөн зээлжих зэрэглэлийн үнэлгээг “В3”, төлөвийг “Тогтвортой” хэвээр хадгалсан.</p> <p>2. Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Фитч агентлагаас 2020 оны 2 дугаар сарын 18-ны өдөр гаргасан тайландаа COVID-19 вирус нь хэрхэн Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх талаар судалгаа гаргасан.</p> <p>3. Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Фитч агентлагаас ээлжит үнэлгээг гаргахтай холбоотойгоор Монголбанкны удирдлагуудтай 2020 оны 3 дугаар сард цахим уулзалт хийв.</p> <p>4. Коронавирусийн тархалттай холбоотойгоор Мүүдис агентлагаас цахим уулзалт зохион байгуулах хүсэлт тавьсны дагуу 4 дүгээр сарын 13-нд цахим уулзалтыг зохион байгуулж, холбогдох мэдээллээр бэлтгэн хүргүүлэв.</p>
		1.7/ гадаад эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийн хүртээмжийг нэмэгдүүлэх;	СЗХ, Монголбанк, Сангийн яам зэрэг зохицуулагч байгууллагууд “Үндэсний санхүүгийн хүртээмжийн стратеги 2019-2022”-ийг хамтран боловсруулж байгаатай холбогдуулан Монголбанкны чиг үүрэгтэй холбогдуулан санал өгч нягт хамтран ажиллав.
		1.8/ иргэдийн санхүүгийн боловсролыг сайжруулах, тэдний хуримтлал үүсгэх идэвх, хандлагыг нэмэгдүүлэх, харилцагчдын эрх ашгийг хамгаалах.	<p>Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх ажлын хүрээнд санхүүгийн талаар суурь ойлголтууд, төсөв болон санхүүгийн төлөвлөлт, хадгаламж, зээл, хөрөнгө оруулалт, санхүүгийн эрсдэлээс хамгаалах (даатгал) гэх мэт ойлголтуудыг холбогдох төрийн болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран сургуулийн насанд, залуу үед, хөдөө орон нутгийн иргэд болон цахим хуудас, мэдээллийн хэрэгслэлээр дамжуулан олон нийтэд санхүүгийн мэдлэг олгох ажлыг хэрэгжүүлж ажиллав. Тухайлбал :</p> <ul style="list-style-type: none"> • Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангид сонгон судлахаар санхүүгийн боловсрол олгох “Бизнес судлал” хичээлийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын тушаалаар 2018 онд батлав. • “Бизнес судлал” судлагдахууныг заах арга зүйн сургалтад түүх, нийгмийн ухааны 1040 багш хамрагдав. • Монгол улсын түүх соёлыг агуулсан “Хуримтлалын бэлгэ тэмдэг”-тэй болов. • Залуу үед санхүүгийн мэдлэг олгох “Хувь хүний санхүү” сэдэвт (1 кредит) хичээлийг 10 их дээд сургууль болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн бүх төвүүдийн сургалтын хөтөлбөрт мэргэжил харгалзахгүйгээр үзэхээр тусгав. • Орон нутгийн иргэдэд зориулсан санхүүгийн мэдлэг олгох 13 төрлийн гарын авлагуудыг боловсруулан түгээв. • БСШУСЯ-ны харъяа Насан туршийн боловсролын үндэсний төв, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Бичил санхүүгийн хөгжлийн сантай хамтран орон нутгийн санхүүгийн сургагч багш бэлтгэх сургалтыг 21 дэх аймагтаа зохион байгуулж

		<p>нийтдээ 729 сургагч багш бэлтгээд байна.</p> <ul style="list-style-type: none"> • Санхүүгийн мэдлэг олгох www.sankhuuginbolovsrol.mn цахим хуудас, санхүүгийн боловсрол пэйж хуудасыг боловсруулан олон нийтэд түгээн ажиллаж байна. • Монгол Улс Олон улсын хүүхэд, залуучуудын санхүүгийн боловсролын байгууллага /Child&Youth Finance International/-ын “Шилдэг түншлэл-2019” шагнал хүртэв. • OECD/INFE Эдийн засгийн хамтын ажиллгааны хөгжлийн байгууллагын Олон улсын санхүүгийн боловсролын сүлжээнд Монголбанк гишүүнээр элссэн болно. • Монголбанк, ХБНГУ-ын Шпаркассе банкны сан, Монголын банкны холбоо, ХБНГУ-ын “Остпригнитц-Руппины Шпаркассе” банкт хамтран “Монгол Улсад банкны мэргэжилтэн бэлтгэх онол, практик хослуулсан сургалт болон Дэлхийн хуримтлалын өдрийг нэвтрүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлээд 3 жил болж байна. <p>Мөн Төв банк /Монголбанкны/-ны тухай хуульд “Банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах” заалт батлагдсан болно.</p> <p>Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тухай хуулийн төсөлийг 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдөр өргөн барилаа.</p>	
	<p>3.1/ 3.Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монголбанк /Н.Баяртсайхан/-нд чиглэл болгосугай:</p> <p>Зээлийн хүүг бууруулах стратегийг 2018 оны эхний хагаст багтаан баталж, Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд танилцуулах;</p>	<ul style="list-style-type: none"> • Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын 2018 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн дугаар А-167/139/399/37 хамтарсан тушаалаар “Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023”-ийг баталж хэрэгжилтийг Монгол Улсын Их Хурлын Эдийн Засгийн Байнгын хороонд албан тоотой танилцуулан ажиллаж байна. • Уг стратегийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Зээлийн хүүг бууруулах стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын 247/А-256/541/59 дугаар хамтарсан тушаалаар 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдөр баталж, төлөвлөгөөний биелэлтийг хагас жил тутам Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлд танилцуулж ажиллахыг СТБЗАА-нд даалгасан болно. Энэ дагуу уг төлөвлөгөөний биелэлт 2020 оны 3 дугаар сарын эцсийн байдлаар 87%-тай байна. <p>Зээлийн хүү 2018-2019 онд 2.5 нэгж хувиар, 2016 оноос 4 нэгж хувиар буураад байна.</p>	
	<p>3.2/ үнийн тогтвортой байдлыг хангах замаар инфляцийн дарамтгүй эдийн засгийн өсөлтийг дэмжих мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх;</p>	<p>Инфляци сүүлийн 3 жилд тогтвортой хадгалагдаж байна. Эдийн засагт эрэлтийг илэрхийлэх инфляци тогтвортой байгаа нь мөнгөний бодлогоор бодит эдийн засгийг дэмжих орон зайг бий болгосон бөгөөд бодлогын хүүг шат дараатай бууруулах замаар ДНБ-ийн өсөлтийг дэмжих, эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалах бодлогыг хэрэгжүүлэв. Инфляци төв банкны зорилтот түвшний орчимд хадгалагдахын зэрэгцээ санхүүгийн зуучлал хэвийн үргэлжилж, санхүүжилтийн өртөг тогтвортой буурснаар эдийн засгийн өсөлт 2017 онд 5.3%, 2018 онд 7.2%, 2019 онд 5.1% байв.</p> <p>“Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний Инфляцийг тогтвортой нам түвшинд байлгах-инфляцийн зорилтот түвшинг хангах зорилт дахь нийт 49 арга хэмжээний 12 бүрэн биелсэн, 34 хэрэгжих шатандаа, 3 хэрэгжиж эхлээгүй арга хэмжээнүүд байна.</p>	
	<p>3.3/ дотоодын мөнгөний зах зээл дэх хадгаламжийн долларжилтыг бууруулах</p>	<p>Санхүүгийн долларжилтыг бууруулах, гадаад валютын захын үр ашгийг нэмэгдүүлэх тухай судалж, арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Монголбанкны</p>	

		<p>цогц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, үндэсний мөнгөн тэмдэгтэд итгэх итгэлийг сэргээх;</p>	<p>Ерөнхийлөгчийн 2019.12.06-ны өдрийн тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсгээс долларжилтын талаар холбогдох судалгаа шинжилгээг гүйцэтгэн, санхүүгийн долларжилтыг бууруулах арга хэмжээний саналыг боловсруулсан.</p> <p>Түүнчлэн хадгаламжийн долларжилтыг бууруулах хүрээнд Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2018 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн ээлжит хуралдаанаар гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг нэмэгдүүлэн 12 хувиар тогтоох, 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит хурлаар банкны гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 3 нэгж хувиар нэмэгдүүлж 15 хувиар тогтоох шийдвэрүүдийг тус тус гаргаад байна. “Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний Санхүүгийн долларжилтыг бууруулах зорилт дахь нийт 8 арга хэмжээний 5 бүрэн биелсэн, 2 хэрэгжих шатандаа, 1 хэрэгжиж эхлээгүй арга хэмжээнүүд байна.</p>
		<p>3.4/ банкны заавал байлгах нөөц, өөрийн хөрөнгийн хэмжээ, хөрвөх чадварын харьцаа зэрэг үзүүлэлтэд тавигдах шаардлагыг уян хатан зохицуулах замаар мөнгөний зах зээл дэх сул чөлөөтэй эх үүсвэрийн ашиглалтыг сайжруулах;</p>	<p>“Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний Банкуудын үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх зорилт дахь нийт 4 арга хэмжээний 1 бүрэн биелсэн, 3 хэрэгжих шатандаа явж буй арга хэмжээнүүд байна.</p> <p>Коронавирусын халдвартай холбоотойгоор Монголбанкнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний хүрээнд Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн ээлжит хурлаар бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 10 хувьд хүргэх, банкны төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 2 нэгж хувиар бууруулж, 8.5 хувьд тогтоох болон бодлогын хүүний коридорыг бодлогын хүүнээс +1, -1 нэгж хувийн өргөнтэй болгон өөрчлөх шийдвэр гаргасан. Түүнчлэн “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, хяналт тавих журам”-ын зарим зохицуулалтад түр хугацаанд өөрчлөлт оруулан банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг 25 хувь байсныг 20 хувь болгож бууруулж, өөрийн хөрөнгийг хамгаалах нөөц зөрчигдөхөд авч хэрэгжүүлэх арга хэмжээг түдгэлзүүлсэн нь банкуудын санхүүгийн чадавхад эерэг нөлөө үзүүлэх, банкны зээл олголтыг нэмэгдүүлэх үр нөлөөтэй.</p>
		<p>3.6/ Зээлийн мэдээллийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг идэвхжүүлж, зээлийн үнэлгээний системд яаралтай шилжих, зээлийн үйл ажиллагааны зардлыг бууруулах, зээлийн мэдээллийн үйл ажиллагаанд хувийн секторын оролцоог хангах замаар зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхэлдэг этгээдийн тоог нэмэгдүүлэх;</p>	<p>Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А-264 дүгээр тушаалаар “Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийн журам”-ыг шинэчилэн баталж, холбогдох хууль, журмын шаардлага хангасан аж ахуйн нэгжийн “Зээлийн мэдээллийн үйлчилгээ эрхлэх” хүсэлтийг хүлээн авч байгаа тухай мэдээллийг 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Монголбанкны цахим хуудсанд байршуулсан. https://www.mongolbank.mn/news.aspx?tid=1&id=2418</p> <p>Өнөөдрийн байдлаар аж ахуйн нэгжээс холбогдох хүсэлтийг ирүүлээгүй байна.</p> <p>“Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний Зээлийн мэдээллийн сан, зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилт дахь нийт 7 арга хэмжээний 5 бүрэн биелсэн, 2 хэрэгжих шатандаа явж буй арга хэмжээнүүд байна.</p>
		<p>3.7/ хэрэглэгчийг хамгаалах хууль, эрх зүйн орчин, хяналт, зохицуулалтыг сайжруулах.</p>	<p>Монгол Улсад анх удаа "санхүүгийн хэрэглэгч" гэсэн нэр томъёог эрх зүйн хувьд тодорхойлж, түүний эрхийг хамгаалах, үүсч болох аливаа санхүүгийн хүндрэл, эрсдлээс өөрийгөө хамгаалах чадавхи болон санхүүгийн мэдлэгийг бий болгох, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үзүүлж буй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой гомдол, маргаанаа хурдан шуурхай шийдвэрлүүлэх, үүнд хяналт тавих төрийн зохицуулагч байгууллагын оролцоо, хяналт, шалгалтыг сайжруулах зорилгоор 9 бүлэг 29 зүйл бүхий</p>

			<p>"Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай" хуулийн төслийг боловсруулж, хууль санаачлагчийн зүгээс 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдөр хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэн хэлэлцүүлж байна. Уг хуулийн төсөл нь "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай" хуулиас тусдаа санхүүгийн салбарын бүхий л үйлчилгээний үндсэн шаардлага, санхүүгийн байгууллагын үүрэг, маргааныг шүүхийн бус журмаар шийдвэрлэх тусгай механизм болох омбудсманыг үүсгэн байгуулж, санхүүгийн хэрэглэгчийн эрхийг нарийвчлан тодорхойлсноор онцлог юм.</p> <p>Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний Зээлийн эрсдэлийг бууруулах, энэ чиглэлд эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох болон Төрийн болон Санхүүгийн байгууллагуудын засаглалыг сайжруулах, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилтууд дахь нийт 49 арга хэмжээний 19 бүрэн биелсэн, 21 хэрэгжих шатандаа, 9 хэрэгжиж эхлээгүй арга хэмжээнүүд байна.</p>
10.	<p>Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2018.05.09 №05/13 /АБГБХ/ЭЗБХ/</p>	<p>1.2 ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууц, сургууль, цэцэрлэг, соёл, урлаг, онцгой байдлын алба, эмнэлэг зэрэг олон нийтийн байгууллагын барилгыг тэргүүлэх ач холбогдол, газар хөдлөлтийн бичил мужлалын эрсдэлийн зэрэглэлээр эрэмбэлж, буулган шинээр барих арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлах, тус төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардлыг 2019 оноос эхлэн жил бүрийн улсын төсөвт тусган шийдвэрлэх, мөн бусад эх үүсвэрээс санхүүжүүлж байх эрх зүйн орчныг бүрдүүлэх;</p>	<p>Барилга, хот байгуулалтын яам 2020 оны төсөвт нийслэлийн 23, аймаг орон нутгийн 52 орон сууцны барилга байгууламжийг буулган шинээр барихад шаардлагатай 260.9 тэрбум төгрөг хөрөнгийг улсын төсөвт тусгуулах саналыг Сангийн яаманд хүргүүлж, батлуулав.</p> <p>Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 126 дугаар тушаалаар "Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам" батлагдсан. Нийслэлийн Засаг даргын 15 удаагийн захирамжаар Баянгол, Баянзүрх, Налайх, Чингэлтэй, Хан-Уул, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн 163 барилгыг буулган, дахин төлөвлөж, барилгажуулахаар шийдвэрлэж 67 багц болгон төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй урилгыг 2015-2019 онд удаа дараа зарласнаар 26 багцын 70 барилгад төсөл хэрэгжүүлэгч шалгарч, журмын дагуу буулган шинээр барих үйл ажиллагаа явагдсаны үр дүнд одоогийн байдлаар 653 айлын 33 орон сууцны барилгыг буулган 1361 айлын 13 орон сууцыг ашиглалтад хүлээн авав.</p> <p>Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих орон сууцны барилгын судалгаа загвар төсөл, гадна инженерийн шугам сүлжээний ажил нийслэлийн 2020 оны төсөвт 1.934.6 сая төгрөг батлагдсан.</p> <p>Нийслэлийн хэмжээнд 2019 оны төсвийн тухай хуульд нийт 18 барилга байгууламжийг буулгаж барих (цэцэрлэг-15, сургууль-2, соёлын төв-1)-аар батлуулан хэрэгжүүлсэн, 2020 оны төсвийн тухай хуульд нийт 11 барилга байгууламжийг буулгаж барих (сургууль-4, цэцэрлэг-6, соёлын барилга 1)-аар батлагдав.</p>
		<p>1.4/ газар хөдлөлтийн гамшгийн үед нэрвэгдэгсдийг эрэн хайх, аврах тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хангалтыг сайжруулах, гамшгаас хамгаалах олон нийтийн сургалт, дадлагын төв байгуулах зардлыг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх;</p>	<p>Онцгой байдлын ерөнхий газрын дэргэд 2013 онд байгуулагдсан Гамшгийн шуурхай удирдлага, Зарлан мэдээллийн төвд сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий холбоо, зарлан мэдээллийн тоног төхөөрөмжийн шинэчлэлийг бүрэн хийж, Үндэсний хэмжээнд гамшгийн үеийн удирдлага, зохицуулалтын системийг нэвтрүүлж 2017 онд Бүсийн төв Орхон, Ховд, Өмнөговь, Дорнод аймгуудад, 21 аймгийн Онцгой байдлын газруудад Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийг байгуулж Онцгой байдлын ерөнхий газартай өндөр хурдны шилэн кабелийн нэгдсэн сүлжээнд холбогдож мэдээ, мэдээллийг шуурхай солилцох боломжийг бүрдүүлсэн.</p> <p>- Эрэн хайх, аврах үйл ажиллагаанд нохойг ашиглах, сургаж дадлагажуулах, нохойн сургагч, хөтлөгчийг бэлтгэх зорилгоор 2017 онд ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадад Эрэлч нохойн албыг байгуулан ажиллаж байна. Эрэлч нохойн албатай болсноор Үндэсний</p>

			аврах бригад, НОБГ-ын Аврах анги-105, бүсийн төвүүд, Булган, Сэлэнгэ, Хэнтий аймгаас нийт 10 алба хаагчийг нохойн хөтөчөөр, 10 албаны нохойг эрэн хайх, аврах чиглэлээр сургаж, дадлагуулсан.
		1.5/ барилгын салбарт мөрдөгдөж байгаа норм, нормативын баримт бичгийг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх талаар арга хэмжээ авах;	Барилга байгууламжийн норм, нормативын сангийн хөрөнгөөр 2019 онд техникийн зохицуулалтын баримт бичиг 3, барилгын норм ба дүрэм 25, барилгын болон техникийн дүрэм, заавар, цомог, аргачлал 52, стандарт 22-ыг тус тус шинээр болон шинэчлэн боловсруулсан байна.
		1.6/ өрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн өнөөгийн тогтолцооны гүйцэтгэчийг шалгаруулах журамд чанар, аюулгүй байдлын шаардлага, хариуцлага зэрэг шалгуур үзүүлэлтүүдийг тэргүүлэх ач холбогдолд тооцох зарчмыг тусган санал боловсруулж, шийдвэрлүүлэх;	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын ээлжит бус чуулганы хуралдаанаар хэлэлцэж, 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр баталсан бөгөөд 2019 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн. Хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр: Тендерт оролцогчдын хариуцлагатай байдлыг нэмэгдүүлж үндэслэлгүй гомдол гаргасан бол тендерийн баталгааг улсын орлого болгох зохицуулалтыг хуулинд тусган батлуулсан; Захиалагчийн шаардсан чанар, аюулгүй байдлын шаардлагыг шалгарсан этгээд хангаж байгаа эсэхийг бусад тендерт оролцогч этгээд танилцаж хяналт тавих боломжийг олгох үүднээс Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаалаар “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”-ыг баталсан; Тендерт оролцохдоо илт худал мэдээлэл ирүүлсэн, гэрээний үүргээ биелүүлээгүй этгээдэд хариуцлага тооцон үүднээс Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 274 дүгээр тогтоолоор Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм, Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журмыг баталсан бөгөөд 2020 оны 5 дугаар сарын байдлаар “тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл”-д 22 этгээдийг бүртгэн Төрийн худалдан авах ажиллагааны цахим хуудас / www.tender.gov.mn /-д байршуулсан. Цаашид хуулийн нэмэлт, өөрчлөлттэй уялдуулан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 13 тендерийн жишиг баримт бичгийг шинэчлэн батлуулахаар ажиллаж байна.
		1.7/ ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулгаж, дахин төлөвлөх болон дагуул хот, суурьшлын бүс шинээр байгуулах үйл ажиллагаанд аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагчдын оролцоог дэмжих арга механизмыг хэрэгжүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлж, шийдвэрлүүлэх.	“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын их хурлын өргөдлийн байнгын хорооны 2018 оны 07 дугаар тогтоол Үндэсний аюулгүй байдлын зөвлөл /ҮАБЗ/-ийн 2018 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 17/12 дугаар зөвлөмжийн дагуу Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, эрүүл, аюулгүй, газар хөдлөлтийн эрсдэл багатай бүс рүү дагуул хот, суурьшлын шинэ бүс байгуулж тэлэх чиглэлээр эрх зүйн орчин бүрдүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч ажилласан талаар тогтоолын хэрэгжилтийн талаар болон холбогдох материалын хамтаар Улсын их хурлын өргөдлийн байнгын хороонд 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 01/1533 тоот албан бичгээр хүргүүлсэн.
11.	Чиглэл өгөх тухай 2018.06.05 №17	1.2/ төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангаж, Засгийн газар, Монголбанкны хамтын ажиллагааг сайжруулах;	Мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхдээ Засгийн газрын холбогдох яамдуудтай тогтмол мэдээлэл солилцож, статистик тоо болон чанарын мэдээллийг цуглуулж бодлогын шийдвэр гаргахдаа ашиглаж, бодлогын уялдааг хангаж ажиллаж байна. Түүнчлэн, жил бүр УИХ-аар батлуулдаг ТМБҮЧ-ийн төслийг боловсруулахдаа ЗГ-ын саналыг албан ёсоор авч байна. Төсөв мөнгөний бодлогын уялдааг хангах зорилгоор дараа оны Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн төслийг УИХ-д өргөн барихаас өмнө СТБЗ-

			<p>ийн хуралдаанаар хэлэлцүүлж байна. Тухайлбал, 2019.09.24-ний өдрийн СТБЗ-ийн ээлжит хуралдаанаар “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2020 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл”-ийг хэлэлцэж, төсөлд СЯ, СЗХ, ХДК-ийн саналыг тусгасан.</p> <p>СТБЗ-ийн 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн ээлжит хуралдаанаар ногоон санхүүжилт, ногоон зээлд тавих тусгайлсан шалгуурыг тодорхойлсон “Монгол Улсын ногоон таксономи”-г хэлэлцэж, хамтарсан тушаалаар батлаад байна. Түүнчлэн уг хуралдаанаар Монголбанкнаас “Макро эдийн засгийн төлөв байдлын талаар” танилцуулсан.</p> <p>2019 онд Монголбанкаас холбогдох байгууллагуудаас хямралын удирдлагын хүрээнд баримтлах бодлого, авч хэрэгжүүлэх арга хэмжээг уялдуулах, хамтын ажиллагааг өргөжүүлэх, харилцан мэдээлэл шуурхай солилцох арга хэмжээг зохицуулахад чиглэсэн Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо болон Хадгаламжийн даатгалын корпорацийн хоорондох “Санхүүгийн хямралын удирдлагын тухай” харилцан ойлголцлын санамж бичгийн төслийг бэлтгэн, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Хадгаламжийн даатгалын корпорацийн саналыг авч тусгаад байна.</p>
		1.5/ “Монголбанканд хийсэн шалгалттай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2017 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг Улсын Их Хуралд танилцуулж, төв банкны засаглал, шийдвэр гаргалтын эрсдэлийг бууруулан хариуцлага, хяналтын тогтолцоог бүрдүүлэх.	<p>Монголбанкны бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлж, олон улсын шилдэг туршлагыг нэвтрүүлэх зорилгоор Төв банкны үндсэн зорилт, үйл ажиллагааны чиглэлээр мөнгөний бодлогын хороо, Банкны хяналт шалгалтын хороог байгуулж, хамтын шийдвэр гаргах зарчмыг төв банкинд нэвтрүүлэх агуулга бүхий Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг УИХ-аас 2018 оны 1 дүгээр сард баталсан билээ. Тус хуулийн дагуу Мөнгөний бодлогын хороо, Банкны хяналт шалгалтын хороо, Монголбанкны захирлуудын зөвлөлийн ажиллах журмыг шинэчлэн баталж, бүрэлдэхүүнийг томилон Монголбанкны үйл ажиллагааны чиглэлээр хариуцах асуудлын хүрээнд бодлого, хэрэгжилт, хяналтын тэнцвэртэй тогтолцоонд тулгуурласан шийдвэр гарган ажиллаж байна.</p>
12.	Чиглэл өгөх тухай 2018.10.30 №32	1.2/ дотоодын нийт бүтээгдэхүүн, инфляцийн түвшин, гадаад худалдааны болон төлбөрийн тэнцэл, гадаад валютын урсгал зэрэг макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн ерөнхий төлөв, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог тогтмол судлан, улирал тутам дүгнэлт гаргаж, Эдийн засгийн байнгын хороонд танилцуулж байх;	<p>Монголбанкнаас дотоодын нийт бүтээгдэхүүн, инфляцийн түвшин, гадаад худалдааны болон төлбөрийн тэнцэл, гадаад валютын урсгал зэрэг макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн ерөнхий төлөв, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог тогтмол судлан, дүгнэлт гаргаж эдийн засгийн байнгын хороонд тогтмол танилцуулж байна. Түүнчлэн мөнгөний бодлогын хэрэгжилт, макро эдийн засгийн талаар улирал бүр тайлагнаж байна. Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн биелэлт, Мөнгөний бодлогын хорооны хэлэлцсэн асуудлууд болон Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн секторын тойм зэрэг тайлан, танилцуулгуудыг улирал тутам хүргүүлж байна.</p>
		1.5/ Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.69 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд 2019 онд багтаан дотооддоо алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэх.	<p>Монгол Улсын ҮАБЗ-ийн 2019 оны Н-05/05 тоот зөвлөмж, ЗГ-ын 2019.05.17-ны өдрийн 196 дугаар тогтоолоор “Алт цэвэршүүлэх үйлдвэр”-ийн төслийг стратегийн ач холбогдол бүхий төслөөр тодорхойлж, төрийн нууцад хамааруулан үйлдвэрийн барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • БНКУ-ын “Данель М” ХХК-тай АЦҮ-ийн ТЭЗҮ боловсруулах гэрээ байгуулан ТЭЗҮ-г 2019.08 сард хүлээн авсан. ТЭЗҮ-г Эрдэс баялаг мэргэжлийн зөвлөлөөр 2019.09.09-ний өдөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулсан. Мөн байгаль орчны ерөнхий үнэлгээг “Глобал Энвайрон” ХХК-иар гэрээний дагуу хийлгэсэн. • Нийслэлийн засаг даргын 2019.08.27-ны өдрийн А/883 тоот захирамжаар

			<p>Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хорооны нутаг дэвсгэрт 4 га талбайг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахаар гэрчилгээ авсан.</p> <p>МУ-ын Ерөнхий сайдын 2019.10.11-ний өдөр БНКУ-д хийсэн айлчлалын үеэр “Үнэт металл боловсруулах инновацийн арга”-ын шууд патент эзэмшигч “Симбат инженеринг” ХХК-тай нийт 81.9 сая ам.долларын хөрөнгө оруулалт шаардсан, түлхүүр гардуулах нөхцөлтэй АЦҮ-ийг барих ажлын гэрээнд гарын үсэг зурсан. “АЦҮ-ийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх” болон “АЦҮ-ийн барилга угсралтын ажлыг эхлүүлэх” ажил санхүүжилт шийдэгдээгүйн улмаас хүлээгдэж байна. АЦҮ-ийг барихад шаардагдах нийт 81,9 сая долларын санхүүжилтээс бусад бүхий л урьдчилсан бэлтгэл ажлууд бүрэн хангагдсан. Төслийн санхүүжилтийн асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, төслийг гадаад, дотоодын эх үүсвэрээр санхүүжүүлэх боломжийн талаар санал боловсруулж Засгийн газарт танилцуулах тухай Монгол улсын Засгийн газрын 2020.2.12 –ны өдрийн 9 дүгээр хуралдаанаас чиглэл авсан.</p> <p>Гадаад, дотоодын банкны зээлийн нөхцөл, тавигдах шаардлагад нийцсэн хөрөнгө оруулалтын нарийвчилсан шинжилгээ хийлгэж, Япон, Швейцар, Сингапурын хөрөнгө оруулалтын банкнуудтай хамтран ажиллаж байна.</p>
		<p>2.1/ газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг эрчимжүүлж, Дорноговь аймгийн нутагт баригдах газрын тос боловсруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг Эдийн засгийн байнгын хороонд 2018 оны 12 дугаар сарын 15-ны дотор танилцуулах;</p>	<p>Газрын тос боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцэж хүлээн авсан.</p> <p>Монгол Улсын Их Хурлын Эдийн Засгийн байнгын хорооны 2018 оны 10 дугаар сарын 30-ний өдрийн “Чиглэл өгөх тухай” 32 дугаар тогтоолын 2 дахь заалтын 1 дэх хэсэгт заасны дагуу газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийн тайланг танилцуулахаар холбогдох материалыг бэлтгэн 2018 оны 12 дугаар сарын 12-ний өдрийн 01/3315 дугаар албан бичгээр УИХ-ын Эдийн Засгийн байнгын хорооны даргад хүргүүлсэн.</p>
		<p>2.3/ Монгол Улс, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах, экологийн өндөр ангилал бүхий чанар, стандартын шаардлагад нийцсэн шатахууны үнийн хөнгөлөлт эдлэх асуудлаар хэлэлцэж тохирох;</p>	<p>Манай улсын шатахууны гол ханган нийлүүлэгч "Роснефть" ХХК-тай 2019.02.18-22-ны өдрүүдэд ОХУ-ын Москва хотноо хийсэн уулзалтаар 2019 онд Монгол улсад нийлүүлэх шатахууны төрөл, тоо хэмжээ, үнийн талаар болон Евро-5 стандартын шатахууны хэмжээг нэмэгдүүлэх, үнийн хөнгөлөлт үзүүлэх талаар санал тавьж хэлэлцсэн. “Роснефть” компанийн хувьд ОХУ-ын дотоодын хэрэгцээг Евро-5 шатахуунаар хангах асуудал бүрэн шийдэгдээгүй байгаа тул Монгол улсад нийлүүлэх Евро-5 стандартын шатахууны хэмжээг нэмэгдүүлэх боломжгүй, компаниудын урьдчилсан захиалгын дагуу боломжит хэмжээгээр нийлүүлэх талаар анхаарч ажиллахаа илэрхийлсэн.</p> <p>Мөн 2019 оны 10 дугаар сард Роснефть компанийн төлөөлөл манай улсад ажиллах үеэр Евро-5 стандартын шатахууны нийлүүлэлтийн хэмжээг нэмэгдүүлэх талаар дахин санал тавьсан бөгөөд Евро-5 /К-5/ ангиллын шатахууны нийлүүлэлтийн хэмжээг 2020 оны 6 дугаар сараас эхлэн нийт бүтээгдэхүүний 50 хувьд хүргэх талаар судлан үзэж, нааштайгаар шийдвэрлэх тухай хүсэлтийг 2019 оны 10 дугаар сард албан бичгээр "РОСНЕФТЬ" ХК-д явуулсан.</p> <p>Өнгөрсөн онд 493,4 мянган тонн автобензин, 1.118.4 мянган тонн дизель түлш, нийт 1.611.8 мянган тонн шатахуун импортлосноос К5 /Евро-5/ стандартын шаардлагад нийцсэн автобензин, дизель түлш 211.7 мянган тонн буюу нийт импортлосон шатахууны 13.1 хувийг эзэлж байна.</p>

13.	Ипотекийн зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар чиглэл өгөх тухай 2018.11.13 №35	<p>2.1/ Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монголбанканд чиглэл болгосугай: ипотекийн зээлийн хөтөлбөрийг Засгийн газарт үе шаттайгаар шилжүүлэх хүртэл уг хөтөлбөрийг санхүүжүүлэх;</p> <p>2.2/ олон улсын санхүүгийн байгууллагуудтай тохирсон нөхцөлийн дагуу Монголбанканд дахь ипотекийн зээлээр баталгаажсан бондын үндсэн төлбөрийн эргэн төлөлтөөс ипотекийн зээлийг санхүүжүүлэх.</p> <p>3. Ипотекийн зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай журам, гэрээнд өөрчлөлт оруулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монголбанк /Н.Баяртсайхан/, Санхүүгийн зохицуулах хороо /С.Даваасүрэн/-нд чиглэл болгосугай.</p>	<p>Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 285/А-334 тоот хамтарсан тушаалын хавсралтаар "Монголбанкийг "Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоо бүрдүүлэх хөтөлбөр"-өөс гаргах төлөвлөгөө"-г баталсан. Төлөвлөгөөний дагуу Монголбанк 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хөтөлбөрийн санхүүжилтийг Засгийн газарт шилжүүлээд байгаа.</p> <p>Монголбанк 2018 онд ипотекийн зээлийн хөтөлбөрийг өөрийн өмчлөлийн ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ИЗББ)-ын үндсэн төлбөрийн орлогоор сар бүр 16 тэрбум төгрөг, нийт 191.36 тэрбум төгрөгийн санхүүжилтийг банкуудаар дамжуулан 2,771 иргэнд, Засгийн газраас Улсын төсөвт тусгасан 118.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 1,920 иргэнд нийт 310 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг 4,691 иргэнд олгосон.</p> <p>Монголбанк 2019 онд хөтөлбөрийн санхүүжилтийн бүтцийг шинэчилснээр банкуудын эх үүсвэрийг татан оролцуулж хөтөлбөрийн хүртээмжийг нэмэгдүүлсэн. Ингэснээр Монголбанк 2019 онд 213.4 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг 3,009 иргэнд, Засгийн газраас 112 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг 1,820 иргэнд, банкууд 118 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг 1,647 иргэнд олгож, нийт 443.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 6,476 иргэнд олгосон байна.</p> <p>УИХ-аас "Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээ"-ний тухай тогтоолын 6.1 дэх заалтад "Эмч, эмнэлгийн ажилтан, төрийн тусгай албан хаагч, ажилтанд зориулсан ипотекийн зээлийн тусгай бүтээгдэхүүн гаргах, барилгын салбарын зээлийн чанар муудахаас сэргийлэх, ажлын байрыг хадгалах зорилгоор Монголбанкнаас олгосон санхүүжилтийн үндсэн төлбөрийн эргэн төлөлтийн хэмжээгээр орон сууцны ипотекийн зээлийг үргэлжлүүлэн санхүүжүүлэх, энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх бүрэн эрхийг Монголбанканд олгох эрх зүйн түр зохицуулалтыг бий болгох хууль тогтоомжийн төслийн санал боловсруулж, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх" үүргийг өгсөн. Үүний дагуу Монголбанкнаас орон сууцны ипотекийн зээлийн эх үүсвэрийг 2020 оныг дуустал банкуудад олгохоор холбогдох эрх зүйн актуудад өөрчлөлт оруулах, гэрээ байгуулах, санхүүжилтийг олгохтой холбоотой ажлуудыг эхлүүлээд байна.</p>
14.	Экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газар, Монголбанканд чиглэл өгөх тухай 2019.04.09 №04	<p>2.1/ Экспортын санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэхийг Монголбанк /Н.Баяртсайхан/-нд, шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Хөгжлийн банк /Б.Батбаяр/-нд тус тус чиглэл болгосугай./</p> <p>гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг эцэслэн боловсруулах, хөрөнгө оруулагч, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг Засгийн газар /У.Хүрэлсүх/-тай хамтран хэрэгжүүлэх;</p>	<p>Монгол Улсын Засгийн Газар болон Айвенхоу Майнз Монголия ХХК, Айвенхоу Майнз Лимитед, Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед компани хоорондын хөрөнгө оруулалтын гэрээний 3 дугаар бүлгийн 19 хэсэгт "Засгийн газраас бичгээр хүсэлт гаргасан бол Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлсэнээс хойш 3 /гурав/ жилийн дотор Хөрөнгө оруулагч Үндсэн үйл ажиллагаанаас гаргасан ашигт малтмалын баяжмалын Бүтээгдэхүүнийг метал болгох, зэс хайлуулах үйлдвэрийг /цаашид "Хайлуулах үйлдвэр" гэх/ Монгол Улсад барих, ажиллуулах эдийн засгийн боломжийн талаархи судалгааны тайланг боловсруулна." гэж заасан байдаг. Үүний дагуу Үндэсний аюулгүй байдлын 2019 оны 2 дугаар сарын 19-ний 05/05 тоот зөвлөмжийн дагуу Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах ажлын хүрээнд Монголбанкны зүгээс "Оюу Толгой" ХХК-ны гүйцэтгэх захирал Армандо Торрестэй уулзсан. "Оюу толгой" ХХК нь дээрх заалтын хүрээнд ТЭЗҮ-ыг боловсруулаагүй бөгөөд товч судалгааг хийсэн байна. Түүнчлэн ҮАБ-ын зөвлөлөөс 2019 оны 05\05 тоот зөвлөмжийн дагуу УУХҮЯ-тай төслийн менежментийн асуудлаар зөвшилцөх чиглэл өгсний дагуу 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр Монголбанк болон УУХҮЯ-ны холбогдох албан тушаалтнуудын уулзалт хийж, 2020 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн Н/21 албан тоот бичгээр дээрх асуудалд Монголбанкны оролцооны талаар хүргүүлээд байна.</p>

14 тогтоолын 63 заалт

Танилцуулга бэлтгэсэн: ХШҮХ-ийн референт Б.Нандингэрэл